

Гарчиг

1. ТӨСЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ.....	2
1.1. Ерөнхий мэдээлэл	2
1.1.1. Төслийн нэр	2
1.1.2. Төслийн зорилго	2
1.1.3. Гүйцэтгэгч.....	2
1.1.4. Гүйцэтгэгчийн хаяг, утас	2
1.1.5. Төслийн талбайн байршил.....	2
1.1.6. Төслийн товч танилцуулга, хүчин чадал.....	3
1.1.7. Уурхайн ажиллах горим	3
1.1.8. Уулын ажлын төлөвлөгөө.....	3
2. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	4
2.1. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гол зорилт, хамрах хүрээ	4
2.2. Нөхөн сэргээлтийн арга хэмжээний биелэлт	7
2.3. 2023 оны дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний биелэлт	9
3. 2023 ОНЫ ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ТАЙЛАН.....	11
3.1. Хөрсний хими, физик шинж чанар, хүнд металлын шинжилгээ	11
3.2. Усны химийн шинжилгээ	11

Зургийн жагсаалт

Зураг 1. Төслийн талбайн байршил	2
Зураг 2. Усалгааны машин	4
Зураг 3. Уурхайн хашаалсан хэсэг.....	6
Зураг 4. Хог хаягдлын төлбөр төлсөн баримт	7
Зураг 5. Сургалтын төлбөр шилжүүлсэн баримт.....	7
Зураг 6. Уурхайн талбайд шинээр суулгасан ба ургаж буй модны байдал	8
Зураг 7. Техникийн нөхөн сэргээлт хийсэн талбай	9
Зураг 8. Бүрэгхангай суманд мод тарьсан.....	9
Зураг 9. Рашааны эхийг хашаалах ажил.....	10

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1. Төслийн талбайн координат цэг.....	2
Хүснэгт 2. Календарьчилсан төлөвлөгөө	3
Хүснэгт 3. Агаар мандалд учруулах сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	4
Хүснэгт 4. Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт.....	5
Хүснэгт 5. Хөрсөн бүрхэвчид учруулах сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	5
Хүснэгт 6. Газрын хэвлийд учруулах сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	5
Хүснэгт 7. Ургамлан бүрхэвчид учруулах сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	5
Хүснэгт 8. Амьтны аймагт учруулах сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	6
Хүснэгт 9. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт.....	6
Хүснэгт 10. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт	7
Хүснэгт 11. Нөхөн сэргээлтийн ажлын хүрээнд хийж гүйцэтгэсэн ажлууд	7
Хүснэгт 12. Дүйцүүлэн хамгаалах нөхөн сэргээлтийн ажлын зардал	10
Хүснэгт 13. 2023 оны БОМТ-ний дагуу хийгдсэн ажлын биелэлтийн зардлын нэгдсэн тооцоо	10
Хүснэгт 14. Хөрсний химийн үндсэн шинж	11
Хүснэгт 15. Хөрсний механик бүрэлдэхүүн	11
Хүснэгт 16. Хөрсний хүнд металл.....	11
Хүснэгт 17. Гадаргын усны химийн найрлага.....	13
Хүснэгт 18. Гүний усны химийн найрлага.....	13

1. ТӨСЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

1.1. Ерөнхий мэдээлэл

1.1.1. Төслийн нэр

“Гэрэлт шинэчлэл” ХХК-ийн “Бүрэг нэртэй алтны шороон ордыг ил болон драгын аргаар ашиглах” төсөл

1.1.2. Төслийн зорилго

Уул уурхайн үйлдвэрлэл хөгжүүлж алт олборлох

1.1.3. Гүйцэтгэгч

Нэр: “Гэрэлт шинэчлэл” ХХК

Улсын бүртгэлийн дугаар: 9011071145

Регистрийн дугаар: 5046483

Тусгай зөвшөөрөл: MV-021324

1.1.4. Гүйцэтгэгчийн хаяг, утас

Хаяг: Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 4-р хороо, Баруун сэлбэ гудамж,
“Хишиг төв”-ийн байр, 6-603 тоот

Утас: 88888636

1.1.5. Төслийн талбайн байршил

Булган аймгийн Бүрэгхангай сумын нутагт Улаанбаатар хотоос баруун хойш 250 км, Бүрэгхангай сумын төвөөс 40 км зайд оршино.

Хүснэгт 1. Төслийн талбайн координат цэг

№	Уртраг	Өргөрөг
1	104° 20' 04.93"	48° 14' 40.82"
2	104° 20' 13.94"	48° 14' 49.83"
3	104° 20' 13.85"	48° 14' 56.88"
4	104° 20' 21.03"	48° 14' 56.92"
5	104° 20' 23.51"	48° 14' 59.04"
6	104° 20' 23.47"	48° 14' 02.12"
7	104° 20' 26.25"	48° 15' 02.12"
8	104° 20' 40.93"	48° 15' 16.82"
9	104° 20' 40.93"	48° 14' 40.82"



Зураг 1. Төслийн талбайн байршил

1.1.6. Төслийн товч танилцуулга, хүчин чадал

“Гэрэлт шинэчлэл” ХХК нь Булган аймгийн Бүрэгхангай сумын нутагт орших Бүрэг нэртэй газар нь MV-021324 дугаартай 43.1 га газар бүхий ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй болно. Уг орд газар нь Улаанбаатар хотоос баруун хойд зүгт 210-250 км, Бүрэгхангай сумын төвөөс зүүн зүгт 40 км-г байрладаг.

Бүрэг нэртэй алтын шороон ордын нөөцийг ЭБМЗ-ийн 2014 оны 07-р сарын 09-ний ХХ-12-17 тоот дүгнэлт, АМГТГ-ын даргын 2014 оны 8-р сарын 04-ний н-132 тоот тушаалаар ашигт малтмалын улсын нэгдсэн нөөцөд бүртгэхдээ нөөцийг зүсэлтийн аргаар хүлээн авсан. Харин ЭБМЗ-ийн 2019 оны 06-р сарын 27-ны Т/19-11-03 тоот дүгнэлт, АМГТГ-ын даргын 2019 оны 08-р сарын 02-ны т/117 тоот тушаалаар хүлээн авсан ТЭЗҮ-д үйлдвэрлэлийн нөөцийн тооцоог блокийн аргаар боловсруулсан байна.

Цаашид үйлдвэрлэлийн нөөцийн тооцоог ТЭЗҮ-д тусгагдасны дагуу тооцоолон төлөвлөсөн. 2022 оны олборлолтын үеийн дундаж бохирдол 3.418 %, хаягдал 4.89 % - тайгаар олборлоно.

2022 он ТЭЗҮ батлагдаснаас хойшхи ашиглалтын 1-р жилд хамаарна. 2022 онд 2022 онд тус ордын С-1, С-2, С-3, В-20-1, В-20-2, В-20-3 блокуудыг бүрэн олборлож дуусах бол С-1-1 блокийн 61.5 %-ийг ашиглана. С-1-1 блокийн үлдэгдэл хэсгийг 2023 онд ашиглана. 2022 онд ашиглалтын хаягдалгүйгээр олборлолтын үйл ажиллагаа явуулахаар төлөвлөсөн ба бохирдлын хувийг ашиглалтын блок тус бүрээр ТЭЗҮ-д тусгагдасны дагуу тооцоо. 2022 онд уурхайгаас нийт 285.61 мян.м³ хөрс хуулж, 139.4485 мян.м³ элс /элсэн дэх металлын хэмжээ 22.1 кг/ олборлоно.

1.1.7. Уурхайн ажиллах горим

Уг орд нь 2023 оны 4-р сараас бэлтгэл ажил эхэлнэ. Уулын ажил хоногт 2 ээлжээр, ээлжийн үргэлжлэх хугацаа 10 цаг байна. 2025 оны 5-10-р саруудад хаалт нөхөн сэргээлтийн ажил хийнэ. Монгол улсын хөдөлмөрийн хуульд заасны дагуу жилд амрах баяр ёслолын хоног цаг тооцон хоног ажиллахаар тооцоо.

1.1.8. Уулын ажлын төлөвлөгөө

Ашиглалтын нийт хугацаанд 130.5 мян.м³ хөрс хуулж, 150.0 мян.м³ элс олборлох ба хөрс хуулалтын итгэлцүүр 1.11 м³/м³ байна. 2023 оны 07 дугаар сараас уулын ажил эхлэх ба В-1 блокоос олборлолт явуулж эхэлсэн үргэлжлэн В-1 блок олборлож дуусгана.

Уулын ажлын календарчилсан төлөвлөгөө:

Хүснэгт 2. Календарчилсан төлөвлөгөө

№	Ашиглалтын хугацаа	Хөрс хуулалт, м ³	Элс олборлолт, м ³	Кхх, м ³ /м ³
1	2023-05 сар	50000	25000	2
2	2023-06 сар	50000	23390	2.14
3	2023-07 сар	50000	25000	2
4	2023-8 сар	50000	25000	2
5	2023-9 сар	50000	25000	2
6	2023-10 сар	35600	15600	2.28
	Нийт	285600	139400	2.05

2. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

“Гэрэлт шинэчлэл” ХХК-ийн “Бүрэг нэртэй алтны шороон ордыг ил болон драгын аргаар ашиглах” төслийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг Монгол улсын “Байгаль орчныг хамгаалах тухай”, “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хууль болон бусад холбогдох хууль, журам, стандартыг баримтлан, “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах аргачлал”-ын дагуу боловсруулсны үндсэн дээр биелэлтийн тайланг хийж гүйцэтгэсэн болно.

2.1. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гол зорилт, хамрах хүрээ

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, стратегийн үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх үндсэн зорилго бүхий эрхзүйн баримт бичиг юм.

Хүснэгт 3. Агаар мандалд учруулах сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

№	Болзошгүй сөрөг нөлөөлөл	Гүйцэтгэсэн ажил	Зардал мян.төг
1	Уурхайн олборлолт болон тээврийн хэрэгслүүдийн үйл ажиллагааны улмаас гарч болох тоосжилтын эх үүсвэрүүд:	Уурхайн дотоод замыг хайрган хучилттай болгож тоосжилтыг багасгасан. 2024 онд дахин хэсэг замыг хайргаар хучина.	-
2	- Уурхайн олборлолтын үеийн хөрс хуулалт, олборлолт, овоолго хийх газар шорооны ажил,	Тоосжилт дарах усалгааг тогтмол хийсэн. (ус ашиглалтын зардал)	-
3	- Уурхайн үйл ажиллагаанд ашиглаж буй тээврийн хөдөлгөөн, тээвэрлэлтэнд явж буй машинуудаас ялгарах хорт бодисуудаар орчны агаар бохирдох	Уурхайн хэмжээнд ашиглагдах машин механизмуудын янданд шүүлтүүр тавьж засвар үйлчилгээг тогтмол хийсэн.	ҮА зардал
Дүн			0.0



Зураг 2. Усалгааны машин

“Бүрэг нэртэй алтны шороон ордыг ил болон драгын аргаар ашиглах” төслийн 2023 оны
Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

Хүснэгт 4. Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

№	Болзошгүй сөрөг нөлөөлөл	Гүйцэтгэсэн ажил	Зардал мян.төг
1	Газрын доорх усыг авч ашигласнаар газрын доорх урсацын горим алдагдах, нөөц, чанарт нөлөөлж болзошгүй	Шатах тослох материалын агуулах болгож контейнарыг ашигладаг бөгөөд 2024 онд ойр орчмыг нь хатуу хучилттай болгохоор төлөвлөж байна.	-
2	Түлш шагахуун, тослох материалууд, бохир ус, химийн янз бүрийн бодисууд алдагдах,	2023 оны зун борооны усыг хуримтлуулж усалгаанд ашиглаж эхэлсэн.	-
3	асгарах зэргээс үүдэн бага гүнд	Ус ашиглах дүгнэлт гаргуулсан.	-
4	орших уст давхарга бохирдох	Ус ашиглах гэрээ хийгдэж байгаа.	-
Дүн			0.0

Хүснэгт 5. Хөрсөн бүрхэвчид учруулах сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

№	Болзошгүй сөрөг нөлөөлөл	Гүйцэтгэсэн ажил	Зардал мян.төг
1	Уурхайн хөрс хуулалт, олборлолт, овоолгууд бий болох түүнд дарагдах, хөрс хүдэр тээвэрлэлтийн улмаас хөрсний эвдрэл үүсэх	Шимт хөрсийг төлөвлөлтийн дагуу байршуулж, усалгаа, арчилгааг хийж байгаа.	Усалгааны зардал
	Ил уурхай, овоолгууд, хаягдлын хуримтлалууд болон бусад холбогдох байгууламжийн үйл ажиллагааны улмаас газрын хэлбэр, төрхөд өөрчлөлт орох	Тээвэрлэлтийг тогтсон маршрутын дагуу хийж олон салаа зам гарахаас сэргийлсэн тэмдэг тэмдэглэгээг байршуулсан.	350.0
2	Уурхайн ухашууд, хоосон орон зай нь хүн амьтдад аюултай нөхцөл, эрсдэл үүсгэх	Төслийн талбай орчим байрлах дахин ашиглагдахгүй эвдрэлд орсон газруудыг нөхөн сэргээж тэгшилсэн.	200.0
3	Уурхайн ухашууд, хоосон орон зай нь хүн амьтдад аюултай нөхцөл, эрсдэл үүсгэх	Уурхайн овоолгуудыг төлөвлөгөөний дагуу засч тэгшилэх ажил тогтмол хийгдэж байгаа.	ҮА-ны зардалд орсон
Дүн			550.0

Хүснэгт 6. Газрын хэвлийд учруулах сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

№	Гүйцэтгэсэн ажил	Зардал мян.төг
1	Уурхайн олборлолтонд өртсөн цаашид ашиглагдахгүй болсон газарт стандартын дагуу нөхөн сэргээлт хийж ургамал ургах нөхцлийг бүрдүүлэн усалгааг хийж байна.	ҮА-ны зардалд орсон
2	Уурхайн олборлолтыг ТЭЗҮ, УАТ-д тусгагдсаны дагуу гүйцэтгэж байна.	ҮА-ны зардалд орсон
3	Төлөвлөгөөний дагуу бус, шаардлагагүй газар хөндөлт хийгүй байна.	-
4	Уурхайн ерөнхий төлөвлөлтийг ТЭЗҮ-д тусгаснаар гүйцэтгэж байна.	ҮА-ны зардалд орсон
Дүн		ҮА зардалд орсон

Хүснэгт 7. Ургамлан бүрхэвчид учруулах сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

№	Болзошгүй сөрөг нөлөөлөл	Гүйцэтгэсэн ажил	Зардал мян.төг
1	Ил уурхай, хаягдал чулуулгийн овоолгод ургамлан бүрхэвч устах, дарагдах	Уурхайн ухаш болон барилга байгууламж зэрэг үйл ажиллагаа явуулж буй хэсгийг хашаалсан.	ҮА-ны зардалд орсон
	Төслийн болон түүний эргэн тойрны нутаг дэвсгэрийн дэд бүтэц болон замын байгууламжуудын нөлөөлөлд өртөж талхлагдах	Төлөвлөгөөний дагуу хийгдэх биологийн нөхөн сэргээлтийн ажил эхлэх болоогүй бөгөөд үйл ажиллагааны улмаас халцарсан газрыг цэвэрлэж усалгаа хийн ургамал ургах нөхцлийг бүрдүүлсэн.	450.0
2	Автомашин хөдөлгөөн, овоолго, тээвэрлэлт зэрэг төслийн үйл ажиллагаанаас үүсэх тоосжилт нь ургамал дээр унаж хуримтлагдаж болзошгүй ба энэ нь цаашдаа ургамал үхэх, ургалт доройтох нөхцлийг бүрдүүлэх	Уурхай хашааг тойруулан болон кемпийн хажууд мод суулгаж усалгаа арчилгааг хийж байна.	Мод тарих ажлын зардалд орсон
Дүн			450.0



Зураг 3. Уурхайн хашаалсан хэсэг

Хүснэгт 8. Амьтны аймагт учруулах сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

№	Болзошгүй сөрөг нөлөөлөл	Гүйцэтгэсэн ажил	Зардал мян.төг
1	Төслийн болон ойр орчны нутаг дэвсгэр дэх уурхайн болон дэд бүтцийн үйл ажиллагаа, ашиглалттай холбоотойгоор амьтны аймгийн нутагшил үгүй болох Хөхтөн, шувууд зэрэг амьтдыг дуу чимээ, гэрэл, машин техникийн ажиллагаа зэрэг уурхайн үйл ажиллагааны улмаас үргээж, дүрвээх ба айлган цочоож болзошгүй	Ажилчдад ан амьтны тухай сургалт явуулж, хууль бусаар ан агнахгүй байх талаар заавар өгсөн.	300.0
		Уурхайг хашаалж мал, амьтан унаж гэмтэхээс сэргийлсэн	-
2	Технологи болон хүний үйл ажиллагаагаар бий болсон орчинтой холбоотойгоор шавьжнуудын тоо толгой нэмэгдэж болзошгүй (шавьжнууд гэрэлд амархан татагддаг).	Уурхайн ойр орчмын ан амьтад уурхайн хог хаягдлаас үүдэлтэй нөлөөлөлд өртөхөөс сэргийлж ахуйн болон аюултай хог хаягдлыг түр хадгалахад анхаарч ажиллаж байна.	Хог хаягдлын зардалд орсон
Дүн			300.0

Хүснэгт 9. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт

№	Болзошгүй сөрөг нөлөөлөл	Гүйцэтгэсэн ажил	Зардал мян.төг
1	Уурхайн ажилчдын ахуйн болон автомашины гаралтай хог хаягдлыг ангилан ялгаж зориулалтын цэг дээр хадгалаагүйн улмаас хөрс, гүний ус, агаар, ургамал, амьтан, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх	Хог хаягдлыг ангилан ялгаж дахин ашиглах боломжтой хаягдлыг дахин боловсруулах газарт өгч байна.	-
2	Хог хаягдлыг нэг цэгт цуглуулан ангилж, битүү саванд хадгалан орон нутагтай хийсэн гэрээний дагуу тогтмол хугацаанд зайлуулж байна.	Хаягдал тос масло хадгалах хэсгийг засч сайжруулах ажлыг 2024 оны төлөвлөгөөнд тусгасан.	500.0
		Хаягдал тос маслыг хадгалах хэмжээнээс хэтэрсэн тохиолдолд дахин боловсруулах газарт нийлүүлж байна.	-
			-

*“Бүрэг нэртэй алтны шороон ордыг ил болон драгын аргаар ашиглах” төслийн 2023 оны
Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан*


	Ажилчдын бие засах газрыг шинээр төлөвлөж доторлогоотой 00 болгохоор 2024 оны төлөвлөгөөнд тусгасан.	-
	Хог хаягдлыг бүртгэлжүүлсэн.	-
	Дүн	500.0



Зураг 4. Хог хаягдлын төлбөр төлсөн баримт

Хүснэгт 10. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт

№		Гүйцэтгэсэн ажил	Зардал мян.төг
1	Удирдлага зохион байгуулалтын орон нутгийн нийгмийн хариуцлагын хүрээнд хийсэн ажлууд	Бүрэгхангай 100 жилийн ойн бүтээн байгуулалтанд хандив	45 000.0
		Бүрэгхангай 100 жилийн ойн бүтээн байгуулалтанд 32 машин элс, хайрганы хандив	10 00.0
2		Дэрст багийн иргэдийн эмчийн үзлэгт хандив өгсөн	100.0
3		Булган аймгийн хүүхдийн сургалтын төлбөрт хандив өгсөн.	12 000.0
		Дүн	67 100.0



Зураг 5. Сургалтын төлбөр шилжүүлсэн баримт

2.2.Нөхөн сэргээлтийн арга хэмжээний биелэлт

Уурхай нь 2023 онд биологийн нөхөн сэргээлт хийгдээгүй бөгөөд хотхоны тохижилт, ногоон байгууламж үүсгэх, арчилгаа тордлогоог хийж гүйцэтгэсэн болно.

Хүснэгт 11. Нөхөн сэргээлтийн ажлын хүрээнд хийж гүйцэтгэсэн ажлууд

№	Хийж гүйцэтгэсэн ажлууд	Зардал мян.төг
1	Уурхайн хашаан дотор нэмж 100 ширхэг суулгац суулгасан.	450.0
2	Бүрэгхангай сумын төвд 500ш чацарганы мод суулгаж, ажилчдыг цалинжуулсан.	5 500.0
3	Уурхайн кемпийн зүүн урд талын талбайд техникийн нөхөн сэргээлт хийсэн	ҮА зардалд орсон
	Дүн	5 950.0



Зураг 6. Уурхайн талбайд шинээр суулгасан ба ургаж буй модны байдал



Зураг 7. Техникийн нөхөн сэргээлт хийсэн талбай



Зураг 8. Бүрэгхангай суманд мод тарьсан

2.3. 2023 оны дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний биелэлт

2023 оны дүйцүүлэн хамгаалах нөхөн сэргээлтийн ажлын хүрээнд орон нутгийн саналаар Дөрөлжийн булгийн эхийг хашиж засах ажлыг хийж гүйцэтгэсэн.

Хүснэгт 12. Дүйцүүлэн хамгаалах нөхөн сэргээлтийн ажлын зардал

№	Зардлын нэр	Нийт үнэ
1	Дөрөлжийн булаг хашаалах ажил	8 000.0
	Нийт	8 000.0



Зураг 9. Рашааны эхийг хашаалах ажил

Хүснэгт 13. 2023 оны БОМТ-ний дагуу хийгдсэн ажлын биелэлтийн зардлын нэгдсэн тооцоо

№	Бүрэлдэхүүн хэсгүүд	Зардал мян.төг
1	Агаар мандалд учруулах сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтийн зардал	0.0
2	Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтийн зардал	0.0
3	Хөрсөн бүрхэвчид учруулах сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтийн зардал	550.0
4	Ургамлан бүрхэвчид учруулах сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтийн зардал	450.0
5	Амьтны аймагт учруулах сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтийн зардал	300.0
7	Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлтийн зардал	500.0
8	Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлтийн зардал	67 100.0
9	Нөхөн сэргээлтийн арга хэмжээний биелэлтийн зардал	5 950.0
10	2023 оны дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний биелэлтийн зардал	8 000.0
11	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт	450.0
	Нийт дүн	83 300.0

3. 2023 ОНЫ ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ТАЙЛАН

3.1. Хөрсний хими, физик шинж чанар, хүнд металлын шинжилгээ Хөрсний агро-химийн болон ус-физикийн шинж чанар.

01 цэгийн хөрсний шинж чанар: Аллювийн элсэнцэр бараан хөрсний нийт үе давхаргад урвалын орчин (pH:2.5) 8.93-9.46 буюу сул хүчиллэгээс шүлтлэг орчинтой, карбонатын давсжилт өнгөн үеээс илрээгүй.

Ялзмагт үеийн зузаан нь 12 см. Ялзмагийн бодис буюу органик бодисын агууламж 0.16-0.20% буюу хөрсний үе давхаргад органик бодисын агууламж хэвийн байна. Хөрсөн дэх нийт хялбар уусах давсжилт буюу хөрсний цахилгаан дамжуулах чадвар (ЕС) нь 0.475-2.070 dS/m байгаа нь бага давсжилттай байна. (Хөрсний ЕС нь 1.2 dS/m-ээс дээш байгаа тохиолдолд бага давсжилттай, 8.64 dS/m-ээс дээш бол хэт их давсжилттай гэж үзнэ).

Хөрсний үржил шимийн үзүүлэлт болох хөдөлгөөнт фосфор 1.4-1.5 мг/100г буюу хэвийн хангамжтай өнгөн үеээс доод үе давхарга руу эрс бууралттай, кали 8.6-8.9 мг/100г буюу хэвийн хангамжтай байна (Мачигины хангамжийн зэргээр үнэлэв).

Хүснэгт 14. Хөрсний химийн үндсэн шинж

Дээжний нэр	pH	Давс, %	ЕС _{2.5} dS/m	Ялзмаг %	CaCO ₃ %	Шингээгдсэн сууриуд мг- экв/100гр		Шим тэжээлийн элементүүд мг/100гр	
						Ca	Mg	P ₂ O ₅	K ₂ O
Кемп орчим	8.93	0.98	2.070	0.17	0.82	8.9	5.4	1.5	5
Хогийн сав	9.33	0.57	1.240	0.20	2.63	8.7	4.4	1.4	10
Карьер орчим	9.46	0.22	0.475	0.16	2.14	8.6	3.8	1.5	13

Энэ хөрсний механик бүрэлдэхүүнд бүдүүн ширхэгтэй хэсэг элс давамгайлсан элсэнцэр механик бүрэлдэхүүнтэй байна. Хөрсний хэсгүүдийн харьцаа нь 0-10 см-т элсэн хэсэг 66.0%, нарийн хэсэг 34.0% байгаа нь элсэнцэр фракц давамгайлсан буюу элсэнцэр хөрстэй байна. Доод үе давхарга руу нарийн ширхэгтэй хэсгийн эзлэх хувь хэмжээ бага зэрэг нэмэгдэж элсэрхэг шавранцар болж байна.

Элсэнцэр хөрс нь ус чийг тогтоон барих чадамж муу ч чийгийн хангамж их нөхцөлд ургамлын үндэс амьсгалах боломжийг нэмэгдүүлдэг, ургах орчин нөхцөлийг бүрдүүлдэг эерэг нөлөөтэй.

Хүснэгт 15. Хөрсний механик бүрэлдэхүүн

Дээжийн нэр	Ширхгийн хэмжээ, % (мм-ээр)						
	1-0.25	0.25-0.05	0.05-0.01	0.01-0.005	0.005-0.001	<0.001	<0.01
Кемп орчим	45.9	25.9	5.9	14.4	4.2	3.6	22.2
Хог хаягдлын орчим	26.0	38.1	15.1	5.9	9.0	5.9	20.8
Карьер орчим	22.9	35.5	12.6	9.2	11.2	8.6	29.0

Хүснэгт 16. Хөрсний хүнд металл

№	Дээжийн нэр	Хүнд металл мг/кг					
		Ni /Никель/	Cd /Кадми/	Pb /Тугалга/	Cu /Зэс/	Zn /Цайр/	Cr /Хром/
1	Кемп орчим	30.7	ND	21.3	18.7	71.8	11.4
2	Хог хаягдлын орчим	16.2	ND	27.1	15.2	61.7	14.3
3	Карьер орчим	30.7	ND	25.2	23.9	50.6	27.4
	Хүлцэх агууламж MNS 5850:2019	150.0	3.0	100.0	100.0	300.0	150.0
	Хортой агууламж MNS 5850:2019	1000.0	10.0	500.0	500.0	600.0	400.0
	Аюултай агууламж MNS 5850:2019	1800.0	20.0	1200.0	1000.0	1000.0	1500.0

3.2. Усны химийн шинжилгээ

Судалгааны талбайн баруун талаар урсах Туул гол түүний томоохон цутгалан Хар бухын гол, Нарийн гол, жижиг салаанууд болох Ар наймган, Хайлааст, Бичигт

хошууны гол болон Цайдам, Хүйтэн, Их цагаан зэрэг нуурууд, жижиг булгууд гадаргуугийн усан сүлжээг бүрэлдүүлдэг. Тус бүс нутагт хамгийн анх гидрогеологийн судалгааг 1979-1981 онд Дарханы ГХЭ-ийн Заамарын анги Туул голын хөндийн доод хэсэгт 1:50000-ын эрэл-зураглалын ажил явуулж /Д. Жамцаа, В. Довжид, Д.Лхагвасүрэн 1981 он/ Туул голын дэнж түүний баруун цутгал Урт-Сайр, Баянбулаг, Цагаанбулаг, Улаан эрэг, Хайлаастын амуудад алтны өндөр агуулга бүхий голын хурдас илрүүлэн, талбайн хэмжээнд уст цэгүүдийн бүртгэл, ус агуулагч хурдас давхаргуудыг ангилан ялгажээ. Энэ бүс нутагт орших шороон ордын гидрогеологийн судалгааны ажил 1982 оноос эхлэн эрчимтэй хийгдэж иржээ. 1980-аад оны сүүлээс Туул голын баруун цутгалан Баянголын адаг орчимд Туул голд гидрометрийн пост ажиллуулж Туул голын урсацын жилийн хэлбэлзэл, усны чанарын судалгааг явуулж Хайлааст, Баянгол, Туулын дэнжийн хэсэг, Тосон, Цагаан булаг зэрэг олон орд газрын ордын гидрогеологийн судалгаа хийж, шавхалт түршилтын ажлууд хийгдэж газрын доорх усны үндсэн параметруудийг тогтоожээ. /ДГХЭ-ийн Туулын 3-р анги, Ш.Баярсайхан, Д.Жаргалан, Бубеников.В.Г. 1986-1988; 1989-1992 он/. Хайлаастын ордыг ашиглах, уурхайн тосгон байгуулах түүний ус хангамжийн судалгааг хуучин нэрээр ЗХУ-ын ПНИИС гидрогеологи, инженер геологийн судалгааг явуулж Цагаан булгийн эхэнд тосгон байгуулах, түүний ус хангамжийн цооногуудыг ашиглалтанд оруулсан байна.

Туул голын ус хурах савын хэмжээнд 44013 км² талбайд жилд 818.0 сая шоо м газрын доорхи усны нөөц баялагтай байж болох тооцоо гаргасан байдаг. Туулын ай савын хэмжээнд тархсан хурдас чулуулагийн нас, литологийн төрлийг нэгтгэж, тэдгээрийн нүх сүвшилт зонхилсон, эсвэл ан цавшилт зонхилсон байдлаар ангилж газрын доорхи усны судлагдсан түвшин хөдөлгөөний төрх зэрэг хүчин зүйлийг харгалзаг ай савын хэмжээнд ус агуулагч 10 бүрдэл, ус агуулагч ан цавлаг 5 бүсийг ялгаж газрын доорхи усны 1 км² талбайд байж болох нөөц баялагаар нь 7 төрөлд хуваасан байдаг.

Туул голын хөндий нь өндөр өргөгдсөн, уулсаар хүрээлэгдсэн, эрс тэс уур амьсгалтай, хүйтний улирал урттай байдаг онцлогтой. Зуны улиралд эх газрын дулаан хуурай нөхцөлтэй байдаг тул хур тундас нь аадар шинжтэй ордог өвөрмөц нутаг гэж үздэг. Жилд унах хур тундасны олон жилийн дундаж хэмжээ 258.1 мм байх бөгөөд үүний 48.4% нь нийлбэр ууршилт, үлдэх 51.6% нь гадаргын болон газрын доорх усны тэжээгдэл болдог гэсэн судалгааг Туул голын сав газрын усны нөөцийн нэгдсэн менежментийн баг хийсэн байдаг. Туул гол, Тосонгийн голын орчим орсон аадар борооны эрчим, хур тундасны хэмжээний тухай тодорхой мэдээлэл байхгүй ойролцоогоор 40-50 мм орчим байдаг гэж үздэг. /2016 он “Шижир алт” тосгоны орчим/ Энэхүү ай савд Туулын, Урд Туулын гэсэн 2 томоохон региональ хагарал байдгийг судлаачид тогтоосон байдаг. Уг ай савыг хүрээлэн байгаа уулс нь газрын доорхи усны тэжээлийн бүс, хотгор хуримтлал нь зөөгдөл хөлийн бүс болдог. Уулс хоорондын артезын ай савын хэмжээнд палеозой, доод цэрд, неоген, дөрөвдөгчийн хурдасны устай бүрдлүүд, устай тектоникийн ан цавын бүс тус тус тархсан байна.

Туул голын хөндийн өргөн нь 100 м-ээс километр илүү, хөндийн хөндлөн огтлолын хэлбэр нь тэвш маягтай, хоёр тал нь ижил бус бөгөөд хажуунаасаа уулсаар шахагдсан байдаг. Гольдролын өргөн нь 40-60 м, гүн нь харгиан дээрээ 0.4-0.5 м, бусад газраа 2 м түүнээс илүү гүнтэй, ихээхэн тахиралдсан салаа, булан тохой, хар ус ихтэй.

Эрэг нь намхан 0.6-1.5 м, тасархай, зарим газраа тэгширсэн, голдуу элсэнцэр-шавраас тогтоно.


Голын усны түвшин нь хур тунадсын хэмжээнээс шууд хамаарч 1.2-1.3 м хэлбэлзэнэ. Өвөлдөө зарим газраа тэс хөлддөг, зундаа үертэй үед 205 м³/сек хүртэл ус өнгөрөөдөг, урсгалын хурд нь 1.2 м/сек хүрнэ. Гольдролын налуужилт нь 0.001. Голын ус нь цэнгэг /0.2-0.4 г/л/, гидрокарбонат-сульфат-натрийн найрлагатай.

Хүснэгт 17. Гадаргын усны химийн найрлага

Булган аймаг Бүрэгхангай сум, гадаргын ус							
Анион	мг/л	мг/экв	%, мг-экв/л	катион	мг/л	мг/экв	%, мг-экв/л
Cl ⁻	45.38	1.28	22.08	Na ⁺ +K ⁺	63.24	2.75	47.50
SO ₄ ²⁻	47.10	0.98	16.94	NH ₄ ⁺	0.70	0.04	0.67
NO ₃ ⁻	7.91	0.13	2.20	Ca ²⁺	36.07	1.80	31.10
NO ₂ ⁻	0.10	0.00	0.04	Mg ²⁺	14.59	1.20	20.73
CO ₃ ²⁻	0.00	0.00	0.00	Fe ²⁺	0.00	0.00	0.00
HCO ₃ ⁻	207.47	3.40	58.74	Fe ³⁺	0.00	0.00	0.00
Дүн	307.96	5.79	100.0	Дүн	114.61	5.79	100.00

Хүснэгт 18. Гүний усны химийн найрлага

Булган аймаг Бүрэгхангай сум, гадаргын ус							
Анион	мг/л	мг/экв	%, мг-экв/л	катион	мг/л	мг/экв	%, мг-экв/л
Cl ⁻	49.63	1.40	16.00	Na ⁺ +K ⁺	73.79	3.21	36.73
SO ₄ ²⁻	100.50	2.09	23.95	NH ₄ ⁺	0.20	0.01	0.13
NO ₃ ⁻	2.75	0.04	0.51	Ca ²⁺	54.11	2.70	30.91
NO ₂ ⁻	0.03	0.00	0.01	Mg ²⁺	34.05	2.80	32.05
CO ₃ ²⁻	0.00	0.00	0.00	Fe ²⁺	0.30	0.02	0.18
HCO ₃ ⁻	317.30	5.20	59.53	Fe ³⁺	0.00	0.00	0.00
Дүн	470.22	8.74	100.0	Дүн	162.45	8.74	100.00



Инженер Геодези ХХК
Хөрс судлалын лаборатори

Утас/Факс: 77278899,77288899

E-mail: soil_lab@geo-mongol.mn

Дээж авсан огноо: 2023 он 11 сарын 17

Шинжилгээ хийсэн огноо: 2023 он 11 сарын 23

Дээж авсан газрын нэр: Булган аймаг, Бүрэгхангай сум

Дээж шинжлүүлсэн байгууллага, хувь хүн: “Гэрэлт шинэчлэл” ХХК

Харилцах утас: 88001098

Дээжийн төрөл: Ус

Эрүүл ахуйн шинжилгээний үр дүн

Лаб №	Нэр	Нийгмийн тоо	Гэлгэсний саяханшар		
			<i>E.coli</i>	<i>Salmonella</i>	<i>Cl.perfringens</i>
23/6224	Хүнсний ус	$2.3 \cdot 10^{10}$	Илрээгүй	Илрээгүй	Илрээгүй

Жич: Энэхүү шинжилгээний хэргийг тухайн дээжэнд хямаарх ба хуульчлан хэрэглэхийг хориглоно.

Шинжилгээ хийсэн стандарт: MNS 6341:2012; MNS 5367:2004; MNS 3297:2019


Лабораторийн эрхлэгч:

Задлан шинжээч:



Л. Цагаанцархи /MS.с/

Б.Номин



Инженер Геодези ХХК
Хөрс судлалын лаборатори

Утас/Факс: 77278899, 77288899

E-mail: soil_lab@geo-mongol.mn

Дээж авсан огноо: 2023 он 11 сарын 17

Шинжилгээ хийсэн огноо: 2023 он 11 сарын 23

Дээж авсан газрын нэр: Булган аймаг, Бүрэгхангай сум

Дээж шинжлүүлсэн байгууллага, хувь хүн: “Гэрэлт шинэчлэл” ХХК

Харилцах утас: 88001098

Дээжийн төрөл: Ус

Эрүүл ахуйн шинжилгээний үр дүн

Лаб №	Нэр	Нийгмийн тоо	Гэдэсний савханцар		
			<i>E. coli</i>	<i>Salmonella</i>	<i>Cl. perfringens</i>
23/6225	Гадаргын ус	$6 \cdot 10^{10}$	Илрээгүй	Илрээгүй	Илрээгүй

Жив: Энэхүү шинжилгээний хариу нь тухайн дээжтэй хамаргах ба хууль ёрын хэрэгсэхийг хориглоно.

Шинжилгээ хийсэн стандарт: MNS 6341:2012; MNS 5367:2004; MNS 3297:2019


Лабораторийн эрхлэгч:

Здлан шинжээч:



М.Цагаандархи /MS.c/

Б.Номин



**ХӨРС СУДЛАЛЫН
ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИ**



Дугаар: 23/2484

ИНЖЕНЕР ГЕОДЕЗИ ХХК

Утас/Факс 77278899, 77288899
E-mail: soil_lab@geo-mongol.mn

Дээж авсан огноо: 2023 он 11 сарын 17

Шинжилгээ хийсэн огноо: 2023 он 11 сарын 20-21

Дээж авсан газрын нэр: Булган аймаг, Бүрэгхангай сум

Координат: -

НДТ: -

Дээж шинжлүүлсэн байгууллага, хувь хүн: “Гэрэлт шинэчлэл” ХХК

Харьцах утас: 88001098

Хөрсний химийн задлан шинжилгээний дүн

№	Лаб №	Дээжний нэр	Гүн, см	рН	Давс, %	ЦДЧ, dsm	Ялтмаг, %	CaCO ₃ , %	Шингэгдсэн суурьд мг- эж/100 гр		Шим тэжээлийн элементүүд мг/ 100 гр	
									Ca	Mg	P ₂ O ₅	K ₂ O
0	1	2	3	4	5	6	7	10	11	12	13	14
1	23/6226	Кемп орчим	-	8.93	0.98	2.070	0.17	0.82	8.9	5.4	1.5	5
2	23/6227	Хог, Хаягдлын орчим	-	9.33	0.57	1.240	0.20	2.63	8.7	4.4	1.4	10
3	23/6228	Карьер орчим	-	9.46	0.22	0.475	0.16	2.14	8.6	3.8	1.5	13

Хөрсний механик бүрэлдэхүүн

№	Лаб №	Дээжний нэр	Гүн, см	Механик ширхэгүүд %, ширхэгийн хэмжээ, мм						
				1-0.25	0.25- 0.05	0.05- 0.01	0.01- 0.005	0.005- 0.001	<0.001	<0.01
1	23/6226	Кемп орчим	-	45.9	25.9	5.9	14.4	4.2	3.6	22.2
2	23/6227	Хог, Хаягдлын орчим	-	26.0	38.1	15.1	5.9	9.0	5.9	20.8
3	23/6228	Карьер орчим	-	22.9	35.5	12.6	9.2	11.2	8.6	29.0

Жич: Энэхүү шинжилгээний хариу нь тухайн цэгийн дээжэнд хамарсах ба хуулбарлан хэрэглэхийг хориглоно.

Шинжилгээ хийсэн арга стандарт:

(MNS 3310:1991, MNS ISO 10390:2001, MNS 6824:2020)


Лабораторийн эрхлэгч:

Л.Цагаандархи /MS.c/

Задлан шинжээч:

О.Дагвийжалам /MS.c/





ХӨРС СУДЛАЛЫН
ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИ



Дугаар: 23/2483

ИНЖЕНЕР ГЕОДЕЗИ ХХК

Утас/Факс 77278899, 77288899

E-mail: soil_lab@geo-mongol.mn

Дээж авсан огноо: 2023 он 11 сарын 17

Шинжилгээ хийсэн огноо: 2023 он 11 сарын 20-21

Дээж авсан газрын нэр: Булган аймаг, Бүрэгхангай сум

Координат: -

НДТ: -

Дээж шинжлүүлсэн байгууллага, хувь хүн: “Гэрэлт шинэчлэл” ХХК

Харилцах утас: 88001098

Уст цэгийн төрөл ба дугаар: Гадаргын ус

Лаб № 23/6225

Усны химийн задлан шинжилгээний дүн

Анион	мг/л	мг/экв	%, мг-экв/л	Катион	мг/л	мг/экв	%, мг-экв/л
Cl ⁻	45.38	1.28	22.08	Na ⁺ +K ⁺	63.24	2.75	47.50
SO ₄ ²⁻	47.10	0.98	16.94	NH ₄ ⁺	0.70	0.04	0.67
NO ₃ ⁻	7.91	0.13	2.20	Ca ²⁺	36.07	1.80	31.10
NO ₂ ⁻	0.10	0.00	0.04	Mg ²⁺	14.59	1.20	20.73
CO ₃ ²⁻	0.00	0.00	0.00	Fe ²⁺	0.00	0.00	0.00
HCO ₃ ⁻	207.47	3.40	58.74	Fe ³⁺	0.00	0.00	0.00
Дүн	307.96	5.79	100.00	Дүн	114.61	5.79	100.00

Анион катионуудын нийлбэр: 422.56 мг/л

HCO₃⁻ ийн хагасыг хассан анион катионуудын нийлбэр: 319.0 мг/л

Хуурай үлдэгдэл: 348.0 мг/л

Ерөнхий хатуулаг: 3.00 мг-экв/л

pH: 8.20

Исэлдэх чанар: 5.28 мг/л

Усны физик шинж. чанар

Шүүгдэсний өнгө: Шаравтар

Үнэр: Үгүй

Амт: -

Буллинггар: Тунгалаг

Тунадас: Үгүй

Усны давсны химийн найрлагын томьёо $M(348.0 \text{ мг/л}) = \frac{HCO-58.74 \text{ Cl}-22.08}{Na+K 47.50 \text{ Ca}-31.10 \text{ Mg}-20.73}$

Тайлбар

Химийн бүрэлдэхүүнээрээ гидрокарбонатын ангийн, натрийн бүлгийн, 2-р төрлийн, чанарын хувьд цэнгэг буюу дунд зэргийн эрдэсжилттэй, зөөлөвтөр ус байна. Шинжилгээ хийсэн арга стандарт:

(MNS 1097:1970, MNS 6271:2011, MNS ISO 10523:2001, MNS ISO 9297:2005, MNS ISO 6059:2005)

Лабораторийн эрхлэгч: Л.Цагаандархи /MS.c/

Задлан шинжээч: О.Алтанцэцэг /MS.c/



ХӨРС СУДЛАЛЫН
ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИ



Дугаар: 23/2485

ИНЖЕНЕР ГЕОДЕЗИ ХХК

Утас/Факс: 77278899, 77288899
E-mail: soil_lab@geo-mongol.mn

Дээж авсан огноо: 2023 он 11 сарын 17

Шинжилгээ хийсэн огноо: 2023 он 11 сарын 20-21

Дээж авсан газрын нэр: Булган аймаг, Бүрэгхангай сум

Координат: -

НДТ: -

Дээж шинжлүүлсэн байгууллага, хувь хүн: “Гэрэлт шинэчлэл” ХХК

Харилцах утас: 88001098

Хөрсний хүнд металл

№	Лаб №	Дээжний нэр	Гүн, см	Хүнд металл мг/кг					
				Ni /Никель/	Cd /Кадми/	Pb /Хар тугалга/	Cu /Зэс/	Zn /Цайр/	Cr /Хром/
1	23/6226	Кемп орчим	-	30.7	ND	21.3	18.7	71.8	11.4
2	23/6227	Карьер орчим	-	16.2	ND	27.1	15.2	61.7	14.3
3	23/6228	Хог, Хаягдлын орчим	-	30.7	ND	25.2	23.9	50.6	27.4
Хүлцэх агууламж /MNS 5850:2019/				150,0	3,0	100,0	100,0	300,0	150,0
Хортой агууламж /MNS 5850:2019/				1000,0	10,0	500,0	500,0	600,0	400,0
Аюултай агууламж /MNS 5850:2019/				1800,0	20,0	1200,0	1000,0	1000,0	1500,0
Элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ стандарт				/MNS 5850:2019/					

*ND-not detect


Жич: Энэхүү шинжилгээний хариу нь тухайн цэргийн дээжтэд хамаарах ба хуульчлан хэрэглэхийг хориглоно.

Шинжилгээ хийсэн арга стандарт:

(MNS ISO 11466:2007)

Лабораторийн эрхлэгч:  Л.Цагаандархи /MS.c/

Задлан шинжээч: О.Дагвийжамал /MS.c/



ХӨРС СУДЛАЛЫН
ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИ



ИНЖЕНЕР ГЕОДЕЗИ ХХК

Утас/Факс 77278899, 77288899

E-mail: soil_lab@geo-mongol.mn

Дугаар: 23/2482

Дээж авсан огноо: 2023 он 11 сарын 17

Шинжилгээ хийсэн огноо: 2023 он 11 сарын 20-21

Дээж авсан газрын нэр: Булган аймаг, Бүрэгхангай сум

Координат: -

НДТ: -

Дээж шинжлүүлсэн байгууллага, хувь хүн: “Гэрэлт шинэчлэл” ХХК

Харилцах утас: 88001098

Уст цэгийн төрөл ба дугаар: Хүнсний ус

Лаб № 23/6224

Усны химийн задлан шинжилгээний дүн

Анион	мг/л	мг/экв	% мг-экв/л	Катион	мг/л	мг/экв	% мг-экв/л
Cl ⁻	49.63	1.40	16.00	Na ⁺ +K ⁺	73.79	3.21	36.73
SO ₄ ²⁻	100.50	2.09	23.95	NH ₄ ⁺	0.20	0.01	0.13
NO ₃ ⁻	2.75	0.04	0.51	Ca ²⁺	54.11	2.70	30.91
NO ₂ ⁻	0.03	0.00	0.01	Mg ²⁺	34.05	2.80	32.05
CO ₃ ²⁻	0.00	0.00	0.00	Fe ²⁺	0.30	0.02	0.18
HCO ₃ ⁻	317.30	5.20	59.53	Fe ³⁺	0.00	0.00	0.00
Дүн	470.22	8.74	100.00	Дүн	162.45	8.74	100.00

Анион катионуудын нийлбэр:

632.66 мг/л

HCO₃⁻ ийн хагасыг хассан анион катионуудын нийлбэр:

474.0 мг/л

Хуурай үлдэгдэл:

514.0 мг/л

Ерөнхий хатуулаг:

5.50 мг-экв/л

pH:

8.22

Исэлдэх чанар:

0.64 мг/л

Усны физик шинж. чанар

Шүүгдэсний өнгө: Өнгөгүй

Үнэр: Үгүй

Амт: -

Буллинг: Тунгалаг

Тунадас: Үгүй

Усны давсны химийн найрлагын томьёо $M (514.0 \text{ мг/л}) = \frac{HCO-59.53 SO-23.95}{Na+K 36.73 Mg-32.05 Ca-30.91}$

Тайлбар

Химийн бүрэлдэхүүнээрээ гидрокарбонатын ангийн, натрийн бүлгийн, 2-р төрлийн, чанарын хувьд цэнгэгдүү буюу харьцангуй ихэвтэр эрдэсжилттэй, хатуу ус байна.

Шинжилгээ хийсэн арга стандарт:

(MNS 1097:1970, MNS 6271:2011, MNS ISO 10523:2001, MNS ISO 9297:2005, MNS ISO 6059:2005)

Лабораторийн эрхлэгч:

Л. Цагаандархи /MS.c/

Задлан шинжээч:

О.Алтанцэцэг /MS.c/



БАТЛАВ
ТУУЛ ГОЛЫН САВ ГАЗРЫН ЗАХИРГААНЫ
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ
Д.НЯМДОРЖ
3033045
УЖА5053

2022 оны 11 дүгээр сарын 07

БАТЛАВ
“ГЭРЭЛТШИНЭЧЛЭЛ” ХХК-ИЙН ЗАХИРАЛ
С.ЭРДЭНЧУУЛГАН

2022 оны 11 дүгээр сарын

УС АШИГЛАХ ГЭРЭЭ

Дугаар УНТ 22/60

Улаанбаатар хот

Нэг. Ерөнхий зүйл

Монгол Улсын Усны тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1-д заасны дагуу “Усны газар”-ын “Дүгнэлт хүргүүлэх тухай” 2022 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн 01/1204 дугаар албан бичгээр ирүүлсэн Дугаар 204 тоот ус ашиглуулах дүгнэлт, Туул голын сав газрын захиргааны даргын 2022 оны 11 дүгээр сарын 07-ны өдрийн А/75 дугаар тушаалаар олгосон ус ашиглах зөвшөөрлийг үндэслэн:

Ус ашиглуулагчийг төлөөлж Туул голын сав газрын захиргааны Усны нөөц, ус ашиглалтыг зохицуулах албаны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Уул уурхай эрчим хүчний ус ашиглалтын асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн П.Энхбаяр, Ус ашиглагчийг төлөөлж Улаанбаатар хот Чингэлтэй дүүрэг, 3-р хороо, Жуулчны гудамж, 34-801 тоот, улсын бүртгэлийн 9011035054 тоот гэрчилгээ, 2721643 регистрийн дугаартай “Гэрэлтшинэчлэл” ХХК-ийн Геологич А.Болор-Эрдэнэ нар ус ашиглах талаар харилцан тохиролцож энэхүү гэрээг 1 жилийн хугацаатай байгуулав.

Хоёр. Гэрээний гол нөхцөл

2.1. *Ус ашиглах зориулалт:* Булган аймгийн Бүрэгхангай сумын нутагт орших MV-021324 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй “Гэрэлтшинэчлэл”-ын алтны шороон ордын үйлдвэрлэл технологийн усыг Туул голоос, унд ахуйн хэрэглээнд өөрийн эзэмшлийн гүний 1 худгаас ашиглана.

2.2. *Нийт ашиглах усны хэмжээ:* 139'450.0 м³ элс олборлон баяжуулахад технологийн болон бусад хэрэглээнд зарцуулах нийт усны хэмжээ: 164'962.0 м³/жил;

2.2.1. *Унд-ахуйд:* 1'647.0 м³;

2.2.2. *Ашигт малтмал олборлон баяжуулахад ашиглах ус:* 113'239.0 м³/жил;

2.2.3. *Уурхайн ухлагаас шавхан зайлуулж ашиглах газрын доорх ус:* 50'076.0 м³/жил.

2.3. *Усны чанар, найрлага:* Улирал бүрийн сүүлийн сард ахуйн болон, хаягдлын нуурын уснаас усны дээж авч итгэмжлэгдсэн лабораториор шинжилгээ хийлгэн, шинжилгээний дүгнэлтийг ус ашиглалтын тайланд хавсарган улирал бүрийн сүүлийн сарын 20-ны дотор Туул голын сав газрын захиргаанд ирүүлнэ.

2.4. *Усны эх үүсвэр:*

2.4.1. *Байршил:* Технологийн болон бусад хэрэглээний усыг өөрийн эзэмшлийн гүний 4 худгаас ашиглана. Худгийн байршлын солбицол 48°15'07.53", 104°19'54.1".

2.4.2. *Барилга байгууламж:* Эргэлтийн усан сангийн эзлэхүүн 2'000.0 м³, тунаах сангийн эзлэхүүн 50'000.0 м³.

2.4.3. *Тоног төхөөрөмжийн нэр, марк:* Уурхайн олборлолтод: HYUNDAI-5000LC маркийн экскаватор 1 ш, HOWO маркийн автосамосвал 3 ш, SHANTUI-SD-16 маркийн бульдозер, HYUNDAI-ZL-50 маркийн утгуурт ачигч 1 ш, HYUNDAI-2900 маркийн экскаватор 1

ш. **Баяжуулалтад ашиглах тоног төхөөрөмж:** СБК-1.4 маркийн хүрдэт шигшүүр 1 ш, Драг-30 маркийн Драг 1 ш, СКО-2 маркийн сэгсрэх ширээ 1 ш, 320 м³/цаг хүчин чадалтай эзлэхүүнт насос 3 ш тус тус ашиглана.

2.5. **Хаягдал усны хэмжээ, стандартын шаардлага:** Хаягдал усыг хүрээлэн буй орчинд нийлүүлэхдээ “Хүрээлэн байгаа орчин, Усны чанар. Хаягдал ус. Ерөнхий шаардлага MNS 4943:2015” стандартын шаардлагыг мөрдлөг болгоно. Стандартаас давсан агууламжтай хаягдал усыг байгальд нийлүүлж буй тохиолдолд Байгаль орчин, аялал жуулчлалын Сайдын 2019 оны А/635 дугаар тушаалаар батлагдсан “Ус бохирдуулсны нөхөн төлбөрийг шатлан өсгөх хэлбэрээр ногдуулах журам”-ын дагуу төлбөр тооцно.

2.6. Хаягдал усан дахь бохирдуулах бодисын хэмжээ: Улирал бүр хоёроос доошгүй хаягдал усны холимог сорьц авч, өөрийн зардлаар байгаль орчны лаборатори болон хөндлөнгийн лабораториор шинжилгээ хийлгэж, хариу дүнг хаягдал ус хаях, зайлуулах дүгнэлт гаргах эрх бүхий байгууллагад улирал бүрийн сүүлийн сарын 15-ны дотор хүргүүлнэ.

2.7. **Бохир ус цэвэрлэх барилга байгууламжийн байршил, хүчин чадал, технологи, цэвэрлэх арга, цэвэрлэгээний түвшин:**

2.7.1. Технологийн хаягдал усыг тунгаах нууранд тунгааж, эргүүлэн ашиглана. Стандартаас давсан агууламжтай хаягдал усанд Байгаль орчин, аялал жуулчлалын Сайдын 2019 оны А/635 дугаар тушаалаар батлагдсан “Ус бохирдуулсны нөхөн төлбөрийг шатлан өсгөх хэлбэрээр ногдуулах журам”-ын дагуу төлбөр тооцно.

2.7.2. Ахуйн бохир ус зайлуулах цэгийг Байгаль орчин, аялал жуулчлалын Сайд, Эрүүл мэндийн Сайдын 2018 оны А/82/128 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан “Ус ашиглагч иргэн, аж ахуйн нэгж байгууллага нь ахуйн бохир ус зайлуулах цэгээ ус тусгаарлагчаар тусгаарлаж тохижуулах журам”-ын дагуу тохижуулж ашиглана.

2.8. **Усны эх үүсвэрийг хамгаалах, усны нөөц хомсдох, бохирдохоос сэргийлэх арга хэмжээ, түүнд зарцуулах хөрөнгийн хэмжээ:**

2.8.1. Усны эх үүсвэрийг хамгаалах усны нөөц хомсдох бохирдохоос сэргийлж жил бүр түүнд зарцуулах хөрөнгийн хэмжээг төсөвт суулган орон нутгийн захиргаа, байгаль хамгаалагчаас санал авч сэргээн засварлах шаардлагатай булаг шандыг тохижуулах.

2.8.2. Техникийн нөхөн сэргээлт 6.0 га талбайд хийнэ. “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд 500 ш мод тарина.

2.9. **Усны тоолуур:** Усны тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.4 дэх заалт, Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2013 оны А-156 дугаар тушаалаар батлагдсан “Ус ашиглалт, хэрэглээг тоолууржуулах журам”-ыг хэрэгжүүлж ажиллана. Тоолуурын заалтын тэмдэглэлийг тогтмол хөтөлж, баталгаажуулна.

2.10. **Ус ашигласны төлбөрийн хэмжээ:**

2.10.1. Ашигт малтмал олборлон, баяжуулахад ашиглах 113'239.0 м³ гадаргын ус ашигласны төлбөрт 27'017'693.0 /Хорин долоон сая арван долоон мянга зургаан зуун ерэн гурван/ төгрөг, уурхайн шүүрлээс шавхан зайлуулж ашиглах 50'076.0 м³/жил газрын доорх усны төлбөрт 49'635'331.0 /Дөчин есөн сая зургаан зуун гучин таван мянга гурван зуун гучин нэгэн/ төгрөг, нийт 79'653'024.0 /Далан есөн сая зургаан зуун тавин гурван мянга хорин дөрвөн/ төгрөгийг Булган аймгийн Татварын хэлтсийн дансанд төвлөрүүлнэ. Төлбөрийг дөрөвдүгээр улиралд бүтэн төлнө.

2.10.2. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2 дахь хэсэгт заасны дагуу усны нөөц ашигласны төлбөрийн орлогыг дараа сарын 10-ны өдрийн дотор төлж барагдуулна;

2.10.3. Гэрээнд зааснаас хэтрүүлэн ашигласан усанд Засгийн газрын 2018 оны 391 дүгээр тогтоолоор батлагдсан “Зөвшөөрсөн хэмжээнээс илүү ашигласан усны төлбөр тооцох журам”-д заасны дагуу төлбөр тооцно.

2.11. Хаягдал усан дахь нэгж бохирдуулах бодист ногдох төлбөрийн хэмжээ: 2021 оны Хаягдал бохир усны дүгнэлтийг 30 хоногийн дотор гаргуулах шаардлагатай.

Гурав. Талуудын эрх, үүрэг

3.1. Гэрээ байгуулагч талууд нь Усны тухай хуулийн 7.5, 13.1.1, 13.1.5, 18.1.4, 19.1.2, 19.1.4, 26.1, 30.1, 30.6, 31.1-д заасан эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

3.2. Ус ашиглагч нь гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй бол Усны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.9, 29 дүгээр зүйлийн 29.3 дугаар заалтуудыг үндэслэн Сав газрын захиргааны шийдвэрээр гэрээг хугацаанаас нь өмнө цуцлах бөгөөд Усны тухай хуулийн 33 дугаар зүйлийн дагуу хариуцлага хүлээнэ.

3.3. Ус ашиглуулах дүгнэлтээр тавьсан шаардлага зөвлөмжийн хэрэгжилтийн хангаж ажиллана.

Дөрөв. Бусад

4.1. Гэрээ нь талууд гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарж баталгаажуулсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

4.2. Ус ашиглуулах дүгнэлт, ус ашиглах зөвшөөрөл, хаягдал усны талаарх дүгнэлт, хаягдал ус зайлуулах зөвшөөрөл нь гэрээний салшгүй хэсэг байна.

4.3. Гэрээний биелэлтийг жил бүр дүгнэж, тэмдэглэл үйлдэнэ.

4.4. Талуудын тохиролцооор гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болох ба бичгээр үйлдэнэ.

4.5. Гэрээг дор дурдсан үндэслэлээр хугацаанаас өмнө цуцалж болно.

4.5.1. Ашиглаж буй усны эх үүсвэр тусгай хэрэгцээнд шилжсэн

4.5.2. Аль нэг тал татан буугдсан бол

4.6. Талуудын хооронд үүссэн маргааныг зөв журмаар шийдвэрлэхийг эрхэмлэх бөгөөд эс зөвшөөрвөл холбогдох шатны шүүхээр шийдвэрлэнэ.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

ТУУЛ ГОЛЫН САВ ГАЗРЫН ЗАХИРГААГ УС АШИГЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:
ТӨЛӨӨЛЖ:

Менежерийн албан үүрэг гүйцэтгэгч

“Гэрэлтшинэчлэл” ХХК-ийн Геологич

Д.ЖАРГАЛ

 *A. Tolsonov*

Усны нөөц, ус ашиглалтыг зохицуулах
албаны даргын албан үүргийг түр орлон
гүйцэтгэгч

Улаанбаатар хот Чингэлтэй дүүрэг, 4-р хороо,
Баруун сэлбэ гудамж, “Хишиг төв”-ийн байр 6-
603 тоот.

П.ЭНХБАЯР

Харилцах утас 9911-0075, 8088-9696.

Туул голын сав газрын захиргааны байр, 2
дугаар давхар, 203 тоот өрөө
Харилцах утас: 7000-3716, 7000-3714.



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

УСНЫ ГАЗАР

Чингүнжавын гудамж, 2 дугаар хороо,
Баянгол дүүрэг, Улаанбаатар хот, 16050
Утас/Факс: (976-51) 26 55 78, (976-51) 26 55 36,
Цахим шуудан: office@water.gov.mn,
Цахим хуудас: www.water.gov.mn

2023. 10. 30 № 01/1269

танай 2023. 09. 26-ны № 19/175 -г

“ГЭРЭЛТ ШИНЭЧЛЭЛ” ХХК-Д

Танай байгууллагын 2023 оны 19/175 тоот албан бичгээр ирүүлсэн хүсэлт, холбогдох баримт бичгийг судалж үзээд Усны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.4 дэх заасны дагуу Булган аймгийн Бүрэгхангай сумын нутагт хэрэгжиж байгаа ашигт малтмалын MV-021324 дугаартай тусгай зөвшөөрөл бүхий алтны шороон ордыг ил аргаар ашиглах төслийн 2023 оны ус ашиглуулах дүгнэлтийг гарган хавсралтаар хүргүүлж байна.

Ирээдүй хойч үедээ усны нөөцөө үлдээхийн төлөө усаа хамгаалъя, хуримтлуулъя, хамтран ажиллая.

Хувийг: Туул голын сав газрын захиргаанд

Хавсралт: 4 хуудастай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



З.БАТБАЯР

D:\2023 onii alban bichig\A5.doc

162333103

УС АШИГЛУУЛАХ ДҮГНЭЛТ

2023 оны 10 дугаар
сарын 30-ны өдөр

Дугаар: 198

Улаанбаатар хот
Утас: 51-265528

1. Аж ахуйн нэгж байгууллага, захирлын нэр, утас, факс, улсын бүртгэлийн болон регистрийн дугаар:

“Гэрэлт шинэчлэл” ХХК, дэд захирал Н.Цэрэн, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 4-р хороо, Баруун сэлбэ гудамж, “Хишиг төв”-ийн байр 6-603 тоот, холбогдох утас: 99110075, 80889696, И-мэйл: gombojav.d@gmail.com, улсын бүртгэлийн дугаар: 9011071145, регистрийн дугаар: 5046483.

2. Төслийн нэр, байршил

Туулын талбайн өмнөд хэсгийн үүсгэл шороон орд болон Бүрэг нэртэй алтны шороон орд нь Улаанбаатар хотоос баруун тийш 201-250 км, Булган аймгийн Бүрэгхангай сумас зүүн тийш 40 км зайд байрладаг. Туул голын сав газарт хамаарагдана.

3. Төсөл хэрэгжүүлэгч

“Гэрэлт шинэчлэл” ХХК;

4. Тусгай зөвшөөрлийн дугаар болон талбайн координат /X,Y/

АМГ-аас 2019.04.10-ны өдөр “Гэрэлтшинэчлэл” ХХК-д Булган аймгийн Бүрэгхангай сумын “Бүрэг” нэртэй газарт 43.10 га талбай бүхий MV-021324 дугаартай ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрлийг олгосон.

Тусгай зөвшөөрлийн дугаар: MV-021324, талбайн хэмжээ: 43.1 га (солбицлын 9 цэг)

Уг талбайн солбицол:

№	Уртраг	Өргөрөг	№	Уртраг	Өргөрөг
1	104°20'40.93"	48°14'40.82"	6	104°20'23.51"	48°14'59.4"
2	104°20'4.93"	48°14'40.82"	7	104°20'23.47"	48°15'2.12"
3	104°20'13.94"	48°14'49.83"	8	104°20'26.25"	48°15'2.12"
4	104°20'13.85"	48°14'56.88"	9	104°20'40.93"	48°15'16.82"
5	104°20'21.03"	48°14'56.92"			

5. Үйлдвэрлэл, үйлчилгээний нэр төрөл зориулалт

Алтны шороон ордыг ил болон драгын аргаар ашиглах.

6. Үйлдвэрийн техник, технологи /ажиллах горим, хүчин чадал/

Баяжуулалтад ашиглах тоног төхөөрөмж:

СБК-1.4 маркийн хүрдэт шигшүүр 1ш	К200 маркийн эзлэхүүнт насос 1ш
Драг-30 маркийн Драг 1ш	МОД-1М1 маркийн тунаах машин 1ш
СКО-2 маркийн сэгсрэх ширээ 1ш	МОД-0.5М маркийн тунаах машин 1ш
ГДШ маркийн хоригт цорго гравитаци 1 ш	

Уурхайн алт гарган авах технологи нь олборлосон элсийг скруббер (хүрдэт шигшүүр)-ээр угаан ангилаад шлюз (хоригт цорго)-ээр /баяжуулалт → гүйцээн баяжуулалт/ баяжуулж, шлихийн аргаар алтыг гарган авна.

Драглайны шийдэлтэй алт гарган авах технологи нь хөрс хуулалт ухах → шидэх (гадаад ба дотоод овоолго), элс олборлолт нь ухах → угаах үйлдвэр гэсэн процессоор явагддаг. Баяжуулалт нь хүрдэн шигшүүрээр угаах төхөөрөмж, гүн, нам дүүргэлтийн шлюз, тунаах машин, баяжуулах ширээний дамжуулагаар угаан баяжуулдаг.

2023 онд уурхайд 61 хүн, хоногт 2 ээлжээр, 20 цагаар, 180 хоног ажиллана. (Уулын ажлын төлөвлөгөө маягт 12, 8, 7-р хуудас)

7. Үйлдвэрлэх, боловсруулах бүтээгдэхүүний хэмжээ

2023 онд 130,500.0 м³ хөрс хуулж, 150,000.0 м³ элс олборлон, баяжуулж 17.53 кг алт гарган авч, борлуулахаар төлөвлөсөн. Биологийн болон дүйцүүлэн хамгаалах нөхөн

сэргээлт хийхгүй. “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд 1.5 га-д 500 ш мод тарина. (Уулын ажлын төлөвлөгөө маягт 3, 10).

8. Усны эх үүсвэр, нөөц, чанар, хоногт ашиглах хэмжээ /шоо.метрээр/

Унд ахуйн усыг Өрмөн уул ХХК-тай байгуулсан гэрээний дагуу 1 км зайд орших Өрмөн уул ХХК-ийн талбайд гаргасан 2 л/с ундрагатай худгаас хангана. Технологийн болон Зам талбайн тоосжилт дарах, ногоон байгууламжид шаардлагатай усыг Туул гол болон уурхайн шүүрлийн уснаас хангана.

“Монгол ус” ТӨААТҮГ-ын 2020.06.29-ний өдрийн 1/309 дугаартай “Гэрэлт шинэчлэл” ХХК-д гаргаж өгсөн усны ашиглах боломжит нөөцийн дүгнэлтэд унд ахуйн хэрэгцээнд “Өрмөн уул” ХХК-ийн эзэмшлийн 172.8 м³/хон ундрагатай өрөмдмөл худгаас гэрээгээр 3.28 м³/хон ус авч ашиглахад, зам талбайн усалгаа, технологийн хэрэгцээнд шаардагдах 1,688.2 м³/хон усыг уурхайд орж ирэх 278.2 м³/хон шүүрлийн уснаас болон 20.0 м³/сек урсацтай Туул голоос хангахад усны ашиглах боломжит нөөцийн хэмжээ хүрэлцээтэй байна.

9. Усны барилга байгууламжууд /нэр, хүчин чадал, хэмжээ хийц, дамжуулах шугам сүлжээний урт, диаметр/

Уурхайн эргэлтийн усан сан 2,000.0 м³ багтаамжтай, тунгаах сан 50,000.0 м³ багтаамжтай. эргэлтийн усан сангаас ус татах шугам хоолой 7.0 м-ийн урттай, 200.0 мм-ийн голчтой, Туул голоос ус татах шугам хоолой 150 мм-ийн голчтой 450 м-ийн урттай байна.

10. Худаа, өргөлтийн станцууд, усны тоолуур, /насосны хүчин чадал, марк/

№	Байршил		Ундарга (л/с)	Насосны марк	Тоолуурын мэдээлэл
1	104°19'54.1"	48°15'07.53"	2.0	К-200	Тоолуургүй

11. Байгаль орчны үнэлгээ, нөхцөл

Туулын талбайн өмнөд хэсгийн үүсмэл шороон орд болон Бүрэг нэртэй алтны шороон ордын байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланг 2020 онд “Грийн солюшн консалтинг” ХХК боловсруулж, батлуулсан.

12. Онцгой нөхцөл

- Улирал бүр хоёроос доошгүй удаа хаягдал усны холимог сорьц авч, байгаль орчны итгэмжлэгдсэн лабораториор шинжилгээ хийлгэж, хариуг улирал бүрийн сүүлийн сарын 15-ны дотор Усны газарт ирүүлэх шаардлагатайг анхаарах;

13. Холбогдох хууль, дүрэм, журам, норм стандартын дагуу усны зарцуулалт:

Байгаль орчин аялал жуулчлалын сайдын 2015 оны А/301 тоот тушаалаар баталсан “Нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхэд зарцуулах усны хэрэглээний норм” болон компанийн уулын ажлын төлөвлөгөөний дагуу тооцоход:

Техникийн хүчин чадлаар тооцоход:

Баяжуулалтад 80.0 м³/цаг хүчин чадалтай скруббер 1ш, 50 м³/цаг хүчин чадалтай драг 1ш ашиглана.

150,000.0 м³ x 4.0 м³ = 600,000.0 м³	технологид шаардагдах усны хэмжээ /УАТ-ний маягт 3/
130 м³/цаг x 20 цаг = 2,600.0 м³/хон	Хоногт угаах элсний хэмжээ
2,600.0 м³/хон x 4.0 м³ = 10,400.0 м³/хон	Хоногт шаардагдах усны хэмжээ
10,400.0 м³/хон x 5 хон = 52,000.0 м³	Эргэлтийн усан санд тогтмол байх усны хэмжээ
150,000.0 м³ : 2,600.0 м³/хон = 58 хон	Элс угаан баяжуулахад зарцуулах хугацаа
10,400.0 м³/хон x 0.2 x 58 хон = 120,640.0 м³	Ууршилт, шүүрэлтээр алдагдах усны хэмжээ
120,640.0 м³ + 52,000.0 м³ = 172,640.0 м³	Технологид шаардлагатай нийт усны хэмжээ
5,000.0 м³ x 2 л/м² x 90 хон = 900.0 м³	Зам талбайн тоосжилт дарахад шаардагдах усны хэмжээ (БОМНУ 43х)

$500 \text{ ш/мод} \times 45 \text{ л/м}^2 \times 10 \text{ удаа} = 225.0 \text{ м}^3$	“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд мод тарихад шаардагдах ус
$276.2 \text{ м}^3 \times 180 \text{ хон} = 50,076.0 \text{ м}^3$	уурхайн ухлагаас шавхан зайлуулах шүүрлийн усны хэмжээ (БОННУ 41х) /технологи, зам, талбайн тоосжилт дарахад ашиглана/
$172,640.0 \text{ м}^3 + 900.0 \text{ м}^3 + 225.0 \text{ м}^3 = 173,765.0 \text{ м}^3$	Технологи, зам талбай, ногоон байгууламжид шаардагдах нийт усны хэмжээ
$(172,640.0 \text{ м}^3 + 900.0 \text{ м}^3 + 225.0 \text{ м}^3) - 50,076.0 \text{ м}^3 = 123,689.0 \text{ м}^3$	гадаргын уснаас ашиглах нийт усны хэмжээ /шүүрлийн усыг эргүүлэн ашиглаж үлдсэн шаардагдах усыг Туул голоос ашиглана/
$61 \text{ хүн} \times 150 \text{ л/хон} \times 180 \text{ хон} = 1,647.0 \text{ м}^3$	Ашиг олох зориулалтаар ахуйн үйлдвэрлэл, үйлчилгээнд ашиглах усны хэмжээ
$173,765.0 \text{ м}^3 + 1,647.0 \text{ м}^3 = 175,412.0 \text{ м}^3$	Нийт шаардагдах усны хэмжээ

14. Холбогдох хууль, тогтоол шийдвэрийн дагуу оногдуулах усны төлбөрийн хэмжээ

Ашигт малтмал баяжуулахад ашиглах $123,689.0 \text{ м}^3$ /жил гадаргын, уурхайн ухлагаас шүүрэх $50,076.0 \text{ м}^3$ /жил газрын доорх, ашиг олох зориулалтаар ахуйн үйлдвэрлэл, үйлчилгээнд ашиглах $1,647.0 \text{ м}^3$ /жил газрын доорх усны төлбөрийг Засгийн газрын 2011 оны 302, 2013 оны 327, 326 дугаар тогтоол, 2022 оны 416 дугаар тогтоолд заасан ашиглалтын зориулалтыг тооцох итгэлцүүр, усны нөөц ашигласны төлбөрийн хувь хэмжээг тус тус үндэслэн урьдчилсан байдлаар тооцвол:

Ашигт малтмал баяжуулахад гадаргын усны нөөц ашигласны төлбөр:

$$1 \text{ м}^3 \text{ гадаргын усны үнэ: } 2,651 \text{ төг/м}^3 \times 0,25 \times 0,9 = 596,475 \text{ төг/м}^3$$

- 2,651 төг/м³ – Засгийн газрын 2011 оны 302-р тогтоолоор Туул голын сав газарт тогтоосон гадаргын усны экологи-эдийн засгийн суурь үнэ;
- (25 %) – Засгийн газрын 2022 оны 416-р тогтоолын (7.а)-д заасан гадаргын усыг ашиглахад тооцох төлбөрийн хувь;
- 0.9 – Засгийн газрын 2013 оны 327-р тогтоолд заасан Туул голын сав газарт тогтоосон гадаргын усыг ашиглахад тооцох итгэлцүүр;

$$123,689.0 \text{ м}^3 \times 596,475 \text{ төг/м}^3 = 73,777,396.28 \text{ төг}$$

Шавхан зайлуулах газрын доорх шүүрлийн усны төлбөр:

$$1 \text{ м}^3 \text{ газрын доорх усны үнэ: } 9,440 \text{ төг/м}^3 \times 0,15 \times 0,7 = 991,2 \text{ төг/м}^3$$

- 9,440 төг/м³ – Засгийн газрын 2011 оны 302-р тогтоолоор Туул талын сав газарт тогтоосон газрын доорх усны экологи-эдийн засгийн суурь үнэ;
- (15%) – Засгийн газрын 2013 оны 326-р тогтоолын (7.в)-д заасан газрын доорх усыг шавхан зайлуулах төлбөрийн хувь;
- 0.7 – Засгийн газрын 2013 оны 327-р тогтоолд заасан Туул голын сав газарт тогтоосон газрын доорх усыг шавхан зайлуулахад тооцох итгэлцүүр;

$$50,076.0 \text{ м}^3 \times 991,2 \text{ төг} = 49,635,331.2 \text{ төг}$$

Ашиг олох зориулалтаар ахуйн үйлдвэрлэл, үйлчилгээнд газрын доорх усны нөөц ашигласны төлбөр:

$$1 \text{ м}^3 \text{ газрын доорх усны үнэ: } 9,440,0 \text{ төг/м}^3 \times 0,15 \times 0,07 = 99,12 \text{ төг/м}^3$$

- 9,440 төг/м³ – Засгийн газрын 2011 оны 302-р тогтоолоор Туул талын сав газарт тогтоосон газрын доорх усны экологи-эдийн засгийн суурь үнэ;
- (15%) –
- 326-р тогтоолын 10-д заасан ашиг олох зориулалтаар ахуйн үйлдвэрлэл, үйлчилгээнд газрын доорх ус ашигласныг тооцох төлбөрийн хувь;
- 0.07 – Засгийн газрын 2013 оны 327-р тогтоолд заасан Туул голын сав газарт тогтоосон ашиг олох зориулалтаар ахуйн үйлдвэрлэл, үйлчилгээнд газрын доорх ус ашигласныг тооцох итгэлцүүр.

$1,647.0 \text{ м}^3 \times 99.12 \text{ төг/м}^3 = 163,250.64 \text{ төг}$

Нийт: $73,777,396.28 \text{ төг} + 49,635,331.2 \text{ төг} + 163,250.64 \text{ төг} = 123,575,978.12 \text{ м}^3$

/Нэг зуун хорин гурван сая таван зуун далан таван мянга есөн зуун далан нийм/

15. Үйлдвэрлэл, үйлчилгээнд усны нөөцийг хэмнэх эргүүлж ашиглах даалгавар

- Хаягдал бохир усыг стандартын шаардлагад нийцүүлэн цэвэрлэж, цэвэрлэсэн усаа зам, талбайн тоос дарах болон ногоон байгууламжийн усалгаанд ашиглах;
- Уурхайн технологид шаардагдах усыг шүүрлийн уснаас эргүүлэн ашиглах;

16. Тавигдах шаардлага, цаашид авах арга хэмжээ, зөвлөгөө

- Усны тухай хуулийн 28.6-д заасны дагуу Туул голын сав газрын захиргаанаас ус ашиглах зөвшөөрөл авч, зохих журмын дагуу гэрээ байгуулах;
- Усны тухай хуулийн 30.1.4-д заасны дагуу ус татах шугам хоолой бүрт баталгаажуулсан тоолуур суурилуулж, тоолуурын заалтаар усны нөөц ашигласны төлбөрийг тооцож, Төсвийн тухай хуулийн 23.6.5-д заасны дагуу төсөвт төвлөрүүлэх;
- Усны тухай хуулийн 28.18-д зааснаар ус ашиглуулах дүгнэлт, холбогдох зөвшөөрөлгүйгээр ус ашиглахыг хориглодог болохыг анхаарах;
- Хаягдал усны дүгнэлтийг дараа жилийн эхний улиралд багтаан гаргуулах;
- Үйл ажиллагаа нь зогсох, тасалдах нөхцөл байдал үүссэн үед Сав газрын захиргаа болон холбогдох төрийн захиргааны байгууллагуудад даруй мэдэгдэж, тухайн оны ус ашиглалтын тайланд тусгаж ирүүлэх;
- Засгийн газрын 2018 оны 391 дүгээр тогтоолоор баталсан журмын дагуу зөвшөөрсөн хэмжээнээс илүү ашигласан усны нөөц ашигласны төлбөрийг шатлан өсгөж тооцохыг анхаарах.
- Усны тухай хуулийн 7.5-д заасны дагуу улсын усны мэдээллийн сан бүрдүүлэхэд шаардлагатай ус ашиглалтын тайлан (газрын доорх усны хяналт шинжилгээний мэдээ, ус ашиглах зөвшөөрөл, гэрээ, гэрээ дүгнэсэн акт, усны нөөц ашигласны төлбөрийн баримт, ус ашиглалтын тоо, хэмжээ)-г 2023 оны 12 дугаар сарын 20-ны дотор Усны газарт office@water.gov.mn цахим хаягаар болон холбогдох газруудад хүргүүлж ажиллах;

УС АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН



Б.МЭНДБАЯР



ХОГ ХАЯГДЛЫН ГЭРЭЭ

№ 10

2023 оны 06 дугаар сарын 15-ний өдөр

Дархан баг

Гэрээний зорилго

Монгол Улсын “Хог хаягдлын тухай” хуулийг хэрэгжүүлж хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх хортой нөлөөллийг арилгах, түүнээс урьдчилан сэргийлэх зорилгоор хог хаягдлыг бууруулах ангилах, цуглуулах, тээвэрлэх, хадгалах, дахин боловсруулах эргүүлэн ашиглах, устгахад оршино.

Гэрээний эрх зүйн үндэслэл

- Хог хаягдлын тухай хууль
- Ариун цэврийн тухай хууль

Гэрээ байгуулагч талууд

Нэг талаас Бүрэгхангай сумын ЗДТГ-ыг төлөөлж Байгаль орчны хяналтын Улсын байцаагч Н.Өсөхбаяр, нөгөө талаас “Гэрэлт шинэчлэл” ХХК-ийн орон нутаг хариуцсан менежер Ё.Баяр нар тохиролцож 2023 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс 2023 оны 11 дүгээр сарын 31-ний өдөр хүртлэх хугацаагаар энэхүү гэрээг байгуулав.

Нэг. Аж ахуйн нэгж байгууллагын эрх үүрэг

Монгол Улсын “Хог хаягдлын тухай” хуулийн 10, 14 дүгээр зүйл, Бүрэгхангай сумын ИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 17-ний өдрийн 6/09 дүгээр тогтоолыг үндэслэн хог хаягдал гаргасны төлбөрт сар бүр 500000 / таван зуун мянга/ төгрөгийг Төрийн сан банкны 100040300947 тоот дансанд шилжүүлж байна.

Аж ахуйн нэгж нь өөрийн ахуйн болон үйлдвэрлэлийн хогийг тогтсон хугацаанд цэвэрлэх, тээвэрлэх, Хог хаягдлын талаарх дүрэм, журам, стандартын шаардлагыг хангаж зориулалтын цэгт хаяж байх.

Аюултай хог хаягдлыг аюултай хог хаягдлын төвлөрсөн байгууламж, эсвэл тогтоосон цэгт зөөн тээвэрлэх буюу булшлах.

Аж ахуйн нэгж нь үйлдвэр, үйлчилгээний явцад үүсэх хог хаягдлын хэмжээ түүний тухай мэдээллийг сумын ЗДТГ-т үнэн зөв мэдээлж байх.

Хог хаягдлыг ангилан хаях талаар зохих мэдээллийг ажилтнууддаа эзэмшүүлж аюулгүй ажиллагааны шаардлагыг ханган ажиллах.

Хоёр. Сумын ЗДТГ-ын эрх үүрэг

Монгол Улсын “Хог хаягдлын тухай” хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4.8 дахь заалтыг үндэслэн аж ахуйн нэгж байгууллагаас гарсан хог хаягдлын төлбөрийг нэхэмжилж авна.

Хуулиар олгсон эрхийн дагуу аж нэгж байгууллага өөрийн ахуйн болон үйлдвэрлэлийн хог хаягдлын хэмжээ түүний талаар өгч буй мэдээлэл, орчны ариун цэврийн байдалд хяналт тавьж шаардлага тавих хэрэгтэй.


Хог хаягдлыг ил асгах, орчин тойрныг бохирдуулах, ариун цэврийн шаардлага хангаагүй нөхцөлд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол Зөрчлийн тухай хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.


Гурав. Бусад

Хог хаягдлын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэнд мэргэжлийн хяналтын байгууллага, бүх шатны Засаг дарга, цагдаа, олон нийтийн байцаагч хяналт тавьж ажиллана.

Хог хаягдлын тухай хуульд өөрчлөлт орсон тохиолдолд төлбөрийн хэмжээнд харилцан тохиролцож гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулна.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН

БҮРЭГХАНГАЙ СУМЫН БАЙГАЛЬ
ОРЧНЫ ХЯНАЛТЫН УЛСЫН
БАЙЦААГЧ  Н.ӨСӨХБАЯР

“ГЭРЭЛТ ШИНЭЧЛЭЛ” ХХК-ИЙН ОРОН
НУТАГ ХАРИУЦСАН
МЕНЕЖЕР ЧЛЭГ  Е.БАЯР
ХХК



БАТЛАВ
БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ
ДАРГА БАРИУН-ЭРДЭНЭ
2023.05.12

**БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ, УУРХАЙ АШИГЛАХ,
ҮЙЛДВЭР БАЙГУУЛАХТАЙ ХОЛБОГДСОН ДЭД БҮТЦИЙГ
ХӨГЖҮҮЛЭХ АЖЛЫН БАЙР НЭМЭГДҮҮЛЭХ ТУХАЙ
ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ГЭРЭЭ**

2023 оны 05-р сарын 22-ны өдөр

№ 403 /2023

Булган сум.

Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 дэх заалт, Засгийн газрын 2015 оны 430, 2016 оны 179 дүгээр тогтоол, Булган аймгийн Засаг даргын “Шинэ хөгжлийн зам” 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрүүдийг үндэслэн нэг талаас Булган аймгийг төлөөлж Булган аймгийн Засаг даргын тамгын газар Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Ганцогт овогтой Давааням нөгөө талаас “Гэрэлт шинэчлэл” ХХК-ийг төлөөлж Захирал Носоо овогтой Цэрэн Цаашид компани гэх/ нар харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.

НЭГ.НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1.Энэхүү гэрээгээр талууд байгаль орчныг хамгаалах, орон нутгийн хөгжилд дэмжлэг үзүүлэх, уул уурхайн олборлолт, боловсруулах үйлдвэрийн үйл ажиллагааг тогтвортой, хэвийн явуулах чиглэлээр хамтран ажиллах, ажлын уялдаа холбоог сайжруулахтай холбогдсон харилцааг зохицуулна.

1.2.Компани нь тухайн тусгай зөвшөөрлийн талбай орших сумын байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, орон нутгийн иргэдийн амьдрах орчныг сайжруулах, ажлын байр нэмэгдүүлэх, дэд бүтцийг хөгжүүлэхэд бодитой хувь нэмэр оруулах төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхэд хамтран ажиллана.

1.3.Энэхүү гэрээ нь Монгол Улсын Үндсэн хууль, Байгаль орчныг хамгаалах тухай, Ашигт малтмалын тухай, Газрын тухай, Газрын хэвлийн тухай, Татварын тухай хууль болон бусад хууль, тогтоомжийн хүрээнд явагдана.

ХОЁР. ХАМРАХ ХҮРЭЭ

2.1.Гэрээний хамрах хүрээг Булган аймгийн нутаг дэвсгэрт хэрэгжиж байгаа компанийн доор дурьдсан үйлдвэр, уурхайн төсөл (цаашид “төсөл” гэх)-үүдийн үйл ажиллагааны хүрээнд буюу үйлдвэр залгах хүртэлх хугацаанд орон нутагтай хамтран ажиллах гэрээ гэж ойлгоно. Үүнд:

2.2.Хамтран ажиллах гэрээг хэрэгжүүлэхэд Талууд дараах үндсэн чиглэлүүдийг баримтална. Үүнд:

2.2.1.Уурхай, төслийн бүтээн байгуулалттай холбоотой дэд бүтцийг хөгжүүлэх,

2.2.2.Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх ажлыг эрчимжүүлэх,

2.2.3.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийг хэрэгжүүлэх, ажлын байрыг нэмэгдүүлэх,

2.2.4.Орон нутгийн жижиг дунд бизнес, хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажилд дэмжлэг үзүүлж, хамтран ажиллах,

2.2.5.Соёлын өвийг хамгаалах,

2.2.6.Боловсрол, эрүүл мэндийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, хамтран ажиллах

2.3. Нутгийн захиргааны байгууллага нь компанийн үйл ажиллагаанд Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу дэмжлэг үзүүлж, хамтран ажиллана.

2.4. Талууд хамтран энэхүү гэрээний 2.2.1-2.2.3-т заасан асуудлаар олон нийтийн хэлэлцүүлэг явуулж болно.

2.5. Компани нь тусгай мэргэжил шаардахгүй ажлын байрыг нэн тэргүүнд үйлдвэр, уурхай байрлаж буй сумын иргэдэд санал болгох, дараагийн шатанд зэргэлдээх сумдын иргэдийг ажлын байраар хангах замаар орон нутгийн иргэдийг авч ажиллуулахад анхаарч ажиллана.

2.6. Компани нь төслийн үйл ажиллагааны нөлөөнд өртсөн орон нутгийн эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулах үүднээс орон нутгийн бизнесийг дэмжих төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх талаар хамтран ажиллана.

ГУРАВ. ЗАСАГ ДАРГЫН ЭРХ, ҮҮРЭГ

3.1.Ерөнхий зүйлс:

3.1.1.Ашигт малтмалын олборлолт, боловсруулах үйлдвэрлэл явуулах хугацаанд тус компанид хууль тогтоомжийн хүрээнд төрийн үйлчилгээ үзүүлж, хяналт тавьж ажиллана.

3.1.2.Аж ахуйн нэгж, байгууллагын захиалгаар мэргэшсэн ажилтан бэлдэхэд дэмжлэг үзүүлнэ.

3.1.3.Шинэ ажлын байр нэмэгдүүлж буй ажил олгогчийг урамшуулан дэмжинэ.

3.1.4.Компанийг ашигт малтмал олборлох, үйлдвэр уурхай байгуулах, цаашид үйл ажиллагаагаа тогтвортой, хэвийн явуулахад орон нутгийн холбогдох байгууллага, албан тушаалтны зүгээс шаардагдах үйлчилгээг шуурхай үзүүлж, дэмжлэг үзүүлнэ.

3.1.5.Аймаг, сумын хөгжилд оруулсан хөрөнгийн зарцуулалтыг жил бүр тооцож, ил тод мэдээллэнэ.

3.1.6.Уул уурхайн салбарын хөрөнгө оруулалтын таатай орчныг бүрдүүлэн байгаль орчинд ээлтэй дэвшилтэт технологийг бүхий л хэлбэрээр дэмжинэ.

3.1.7.Орон нутгийн иргэдийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээг аж ахуйн нэгж, байгууллагад сурталчилна.

3.1.8.Татварын хууль, эрх зүйн орчинг боловсронгуй болгох саналыг хамтран хүргүүлнэ.

3.2.Дэд бүтцийг хөгжүүлэх чиглэлээр.

3.2.1.Уурхай, төслийн дэд бүтцийн үйл ажиллагаатай холбогдуулан гаргасан хүсэлтийг шуурхай шийдвэрлэн компанийн үйл ажиллагааг тогтвортой, хэвийн явуулах нөхцөл бололцоогоор хангана.

3.2.2.Уурхайн жигд, тогтвортой үйл ажиллагааг хангах, өргөтгөх, ашиглахаар гаргасан хүсэлтийг шуурхай шийдвэрлэн, шаардлагатай дэмжлэгийг үзүүлж ажиллана.

3.2.3.Уурхайн үйл ажиллагаанд шаардлагатай газрыг эзэмших, ашиглах хүсэлтийг түргэн шуурхай шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлж хамтран ажиллана.

3.2.4.Уурхайн орчны аюулгүй байдлыг хангах нөхцөлийг бүрдүүлсэн эсэхэд хяналт тавьж ажиллана.

3.3.Байгаль орчныг хамгаалах чиглэлээр.

3.3.1.Компанийн тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллана.

3.3.2.Компаниас орон нутагт зохион байгуулж байгаа байгаль орчны чиглэлийн танилцуулга, сургалт, өдөрлөгт иргэд, олон нийтийг идэвхтэй оролцуулна.

3.3.3.Байгаль орчинд ээлтэй, ногоон бизнесийн үйл ажиллагаа, дэвшилтэт технологийг бүхий л хэлбэрээр дэмжих, баталгаажуулахад туслаж, урамшуулна.

3.4.Хөдөлмөр эрхлэлт, ажлын байрыг нэмэгдүүлэх, ажиллах хүчнийг сургах чиглэлээр.

3.4.1. Компанийн захиалгаар мэргэшсэн ажилтан бэлтгэхэд дэмжлэг үзүүлэх.

3.4.2. Компанийн зарласан ажлын байрны мэдээллийг иргэдэд ил тод, нээлттэй хэлбэрээр хүргэх ажлыг зохион байгуулах, орон нутгийн телевиз, радио, сонингоор түгээх.

3.4.3. Төслийн бүтээн байгуулалт, туршилт тохиргоо, зүгшрүүлэлтийн ажил, зөвлөх үйлчилгээ үзүүлэх гэрээгээр зайлшгүй ажиллах шаардлагатай гадаад, дотоод ажиллагсдын хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх.

3.5.Орон нутгийн хөгжилд хувь нэмэр оруулах чиглэлээр.

3.5.1.Компанийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авахтай холбогдсон мэдээллийг иргэдэд хүргэн ил тод, нээлттэй хэлбэрээр хүргэх ажлыг зохион байгуулах;

3.5.2.Компанийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авахтай холбогдсон шалгуур үзүүлэлт, тавигдах шаардлагуудыг орон нутгийн бизнес эрхлэгч, иргэдэд танилцуулахад хамтран ажиллах.

ДӨРӨВ. КОМПАНИЙН ЭРХ, ҮҮРЭГ

4.1.Ерөнхий зүйлс.

4.1.1. Уурхай, төслийн хүрэн дэх үйл ажиллагааг хэвийн тасралтгүй явуулахад орон нутгийн зүгээс аливаа саад тогтор учруулсан тохиолдолд компани нь холбогдох байгууллагаар уг асуудлыг шийдвэрлүүлэх эрхтэй.

4.1.2. Ажиллагсдыг гэнэтийн ослын болон эрүүл мэндийн даатгалд бүрэн хамруулж, нийгмийн даатгал болон хүн амын орлогын албан татварыг орон нутагт төлнө.

4.1.3. Хөдөлмөрийн тухай хуулийн хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэн, одой хүнийг ажлын байраар хангах буюу ажиллуулаагүй бол холбогдох хууль, тогтоомжийн дагуу мөнгөн төлбөрийг орон нутгийн ХЭДС-д төлнө.

4.1.4. Монгол Улсын хуулийн дагуу орон нутгийн албан татварыг тайлагнаж, нийгмийн даатгалын болон татварын өр төлбөргүй ажиллана.

4.1.5. Гамшиг, осол, гал түймэр гарсан үед сайн дурын үндсэн дээр тухайн сум, орон нутагт техник, тоног төхөөрөмж, ажиллах хүчний болон шаардлагатай бусад туслалцаа үзүүлнэ.

4.1.6. Уул уурхайн болон боловсруулах үйлдвэрийн үйл ажиллагааг сум, орон нутгийн иргэдэд сурталчилна.

4.2.Дэд бүтцийг хөгжүүлэх чиглэлээр.

4.2.1. Уул уурхайн бүтээгдэхүүн тээвэрлэх авто тээврийн замын маршрутыг аймгийн Засаг даргаар батлуулж, замыг хайрган хучилттай болгон тогтмол засвар арчилгааг хийж, бүтээгдэхүүн тээврийн авто машинуудыг бүрэн хучлагатай болгоно.

4.2.2. Ашигт малтмалын бүтээгдэхүүний тээврийг орон нутгийн жолооч, аж ахуйн нэгжээр хийлгэхэд түлхүү анхаарна.

4.2.3. Төслийн үйл ажиллагааны нөлөөлөлд өртөх сумын хот төлөвлөлт болон засаглалыг сайжруулахад аймаг болон сумдын засаг захиргааны байгууллагатай хамтран ажиллаж, дэмжлэг үзүүлж, орон сууцжуулах хөтөлбөр хэрэгжүүлэхэд болно.

4.2.4. Харьяалах дэд бүтцийн асуудлыг шийдвэрлэхэд хоёр тал идэвх санаачлага гарган хамтран ажиллана.

4.3.Байгаль орчныг хамгаалах чиглэлээр.

4.3.1. Төслийн байгаль орчинд үзүүлж буй нөлөөлөл, түүнийг бууруулах, хамгаалах чиглэлээр хийсэн ажлын тайланг орон нутгийн иргэдэд танилцуулна.

4.3.2. Техникийн болон биологийн нөхөн сэргээлтийг стандартын дагуу чанартай хийж, хууль бусаар ашигт малтмал олборлосон эзэн холбогдогчгүй эвдэрсэн газрыг нөхөн сэргээхэд дэмжлэг үзүүлнэ.

4.3.3. “Тэрбум мод” үндэсий хөдөлгөөний хүрээнд 3.2 га талбайг хашиж хамгаалан 6000 ширхэг мод тарьж, ургуулна

4.3.4. Аймаг болон сумдын төрийн байгууллагууд, нутгийн иргэдийг уурхайн нөхөн сэргээлтийн үйл ажиллагаатай танилцуулах ажлыг орон нутгийн захиргааны байгууллагатай хамтран зохион байгуулна.

4.3.5. Уурхай, үйлдвэрлэлд ашиглаж байгаа худгийг бүрэн тоолууржуулж, усны ашиглалтын хяналтыг нэвтрүүлнэ.

4.3.6. Худаг засварлах, шинээр гаргах, булаг хамгаалах зэргээр бэлчээрийн усан хангамжийг сайжруулахад хамтран ажиллана.

4.3.7. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгагддаг агаар, ус, хөрсний шинжилгээг Булган аймаг дахь лабораториудаар жилд 1-ээс доошгүй удаа хийлгэнэ.

4.3.8. Сумын төвийн хүн амын усан хангамжийг сайжруулах, эрүүл ахуйн шаардлага хангасан усаар хангахад дэмжлэг үзүүлнэ.

4.3.9. Сумын төвийн нэгдсэн хогийн цагийг дарж булшлах, хог хаягдлын менежментийг сайжруулахад дэмжлэг үзүүлнэ.

4.3.10. Ашиглалт, олборлолтын ажлыг ТЭЗҮ, уулын ажлын төлөвлөгөөний дагуу ажиллана

4.3.11. Орон нутгийн засаг захиргаатай хамтран биологийн төрөл зүйлийг хамгаалах, нөхөн сэргээх ажилд хамтран ажиллаж, дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлнэ.

4.4.Хөдөлмөр эрхлэлт, ажлын байр нэмэгдүүлэх, ажиллах хүчнийг сургах чиглэлээр.

4.4.1. Ажлын байрны захиалгыг аймгийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний газарт ирүүлж, ажил хайгч бүртгэлтэй иргэдээс ажлын ярилцлага хийх журмаар сонгон авч ажиллуулна.

4.4.2. Орон нутгийн хөдөлмөр эрхлэх боломжгүй зорилтот бүлгийн иргэд, сайн дурын бүлгийг “захиалгат бараа бүтээгдэхүүн нийлүүлж хөдөлмөрийн хөлсийг олгох журмаар” дэмжин ажиллана

4.4.3. Компани нь нарийн мэргэжлийн инженер, техникийн ажиллагсдыг шаардлагатай тохиолдолд дотоод, гадаадын их, дээд сургуульд өөрийн зардлаар сургаж мэргэшүүлж болно.

4.4.4. Компани нь Монгол Улсын магадлан итгэмжлэгдсэн их, дээд сургуулиудад бакалаврын түвшинд суралцаж буй оюутнуудад, сурлага, урлаг, спортын өндөр амжилт гаргасан болон зорилтот бүлгийн хүүхдүүдэд санхүүгийн туслалцаа үзүүлдэг тэтгэлэгт хөтөлбөрийг үргэлжлүүлэн ажиллана.

4.4.5. Компани нь төслийн үйл ажиллагаа явуулж буй сумдын сургууль, цэцэрлэгийг сайжруулахад дэмжлэг үзүүлж, Булган аймаг болон сумдтай хамтран ажиллана.

4.4.6. Компани нь аймгийн иргэдэд мэргэжил олгох, шаардлагатай ур чадвар, мэдлэг, практик туршлага эзэмшүүлэхэд чиглэсэн төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд аймгийн эрх бүхий байгууллагуудтай хамтран ажиллана.

4.4.7. 2023-2024 оны хичээлийн жилд 1 оюутны сургалтын төлбөр 4,500,000 мянган төгрөг, 1 оюутны сургалтын төлбөр ~~4,500,000~~ төгрөгийг аймгийн ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн 100040051416 (Төрийн сан)-д 2023 оны 7 дугаар сард багтаан төвлөрүүлнэ.

450 - 12,000,000

4.5.Соёлын өвийг хамгаалах чиглэлээр.

4.5.1.Үйл ажиллагааны явцад орон нутгийн ард иргэдийн ёс заншил, өв уламжлалыг хүндэтгэнэ.

4.5.2.Орон нутгаас санал болгосон хэрэгжүүлэх боломжтой соёлын өвийг хамгаалах төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд хамтран ажиллана.

4.5.3.Орон нутгийн уламжлалт ариун дагшин газар буюу сүсэг бишрэлийн хувьд ач холбогдолтой уул, овоо, рашаан ус зэрэг байгалийн онцлог тогтоцуудыг орон нутагтай хамтран хамгаалах, орчны тохижилтыг сайжруулах арга хэмжээг авна.

4.5.3.Орон нутгийн уламжлалт ариун дагшин газар буюу сүсэг бишрэлийн хувьд ач холбогдолтой уул, овоо, рашаан ус зэрэг байгалийн онцлог тогтоцуудыг орон нутагтай хамтран хамгаалах, орчны тохижилтыг сайжруулах арга хэмжээг авна.

4.5.4.Аялал жуулчлалыг хөгжүүлэхэд хамтран ажиллана.

4.6.Орон нутгийн бизнесийн хөгжилд хувь нэмэр оруулах чиглэлээр.

4.6.1.Нутгийн иргэд, аж ахуйн нэгжийн үйлдвэрлэсэн болон санал болгосон бараа бүтээгдэхүүн хүнсний аюулгүй байдал, эрүүл ахуйн стандартын шаардлага хангасан тохиолдолд эхний ээлжинд худалдан авах бодлого баримтлана.

4.6.2.Компанид шаардлагатай бараа, материал нийлүүлэх жижиг дунд үйлдвэрийн төсөл, хөтөлбөрийг судлан хэрэгжүүлэх, боломжтой төсөл хөтөлбөрийг дэмжиж ажиллана.

4.6.3.Хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд бүтээгдэхүүн /мах, сүү, төмс, хүнсний ногоо/-ийг худалдан авах

4.6.4.Компани нь төслийн нөлөөлөлд өртсөн малчин өрхөд зориулсан малчдын амьжиргааг сайжруулах хөтөлбөрт хамруулах саналуудыг орон нутгийн удирдлагууд, холбогдох мэргэжилтнүүдтэй хамтран боловсруулж ажиллана.

4.6.5.Гамшиг, осол, гал түймэр гарсан үед сайн дурын үндсэн дээр тухайн сум, орон нутагт техник, тоног төхөөрөмж, ажиллах хүчний болон шаардлагатай бусад тусалцаа дэмжлэгийг үзүүлнэ.

ТАВ. ГЭРЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ

5.1. Талууд гэрээг тухай жилийн 2 дугаар улиралд багтаан байгуулж, гэрээний ил тод байдлыг хангах зорилгоор тухайн орон нутгийн иргэдэд гэрээ байгуулсан талаар мэдээлэх бөгөөд гэрээ, түүнтэй холбогдсон баримт бичгийг талуудын цаом хуудсанд ажлын 3 хоногийн дотор байршуулна. Гэрээний хувийг ажлын 5 хоногийн дотор аймгийн Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлагын дэд зөвлөлд хүргүүлнэ.

5.2. Талууд гэрээний хэрэгжилтийг Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс 02 дугаар сарын 20-ны өдрийн дотор дүгнэж, аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн танилцуулна.

5.3. Орон нутгаас энэхүү гэрээнд заагаагүй буюу Компанийн үүрэг хүлээгээгүй асуудлаар аливаа хүсэлт гаргасан, хандив, тусламж хүссэн, мөн заагаагүй асуудлаар хамтарч ажиллах тохиолдолд Компани энэхүү гэрээгээр хүлээсэн үүрэгтээ дүйцүүлэн тооцох бөгөөд дүйцүүлэн тооцсон үүргийг гүйцэтгэсэнд тооцно.

ЗУРГАА. ГЭРЭЭНИЙ ХАРИУЦЛАГА

6.1.Талууд үйл ажиллагаандаа Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийг удирдлага болгоно.

6.2. Энэхүү гэрээг биелүүлэхэд хоёр тал санаачилга гаргаж ажиллана.

6.3. Гэрээгээр хүлээсэн эрх, үүргээ гуравдагч этгээдэд шилжүүлэхийг хориглоно.

6.4.Талууд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ. Энэхүү гэрээ нь компанийг хуулиар хүлээсэн бусад үүргээс чөлөөлөх үндэслэл болохгүй.

ДОЛОО. МАРГААН ШИЙДВЭРЛЭХ

7.1. Гэрээг тайлбарлах болон гэрээний хэрэгжилттэй холбоотой маргаан, зөрчлийг тухай бүр, эв зүйгээр шийдвэрлэхийг эрхэмлэнэ.

7.2. Хэрэв маргаантай асуудлаар талууд тохиролцоонд хүрээгүй тохиолдолд Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу Монгол Улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.

8.2. Давтагдашгүй хүчин зүйлсийн улмаас гэрээг хугацаанаас өмнө дуусгавар болгож болно. Энэ тухайгаа нэг сарын өмнө нөгөө талд бичгээр мэдэгдэнэ.

8.3. Талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр гэрээнд зөвхөн бичгээр нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

8.4. Хэрэв гэрээнд ямар нэгэн өөрчлөлт оруулах шаардлага гарвал нөгөө талдаа 30 хоногийн өмнө харилцан бичгээр мэдэгдэнэ. Оруулсан нэмэлт өөрчлөлтийг гэрээнд хавсаргаснаар нэмэлт, өөрчлөлт нь энэхүү гэрээний нэгэн адил хүчинтэй байх бөгөөд гэрээний салшгүй хэсэг болно.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗАР ХӨГЖЛИЙН БОДЛОГО
ТӨЛӨВЛӨЛТ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН
ХЭЛТСИЙН ДАРГА

..... / Г. ДАВААНЯМ

“ГЭРЭЛТ ШИНЭЧЛЭЛ” ХХК -ИЙН
ЗАХИРАЛ

..... / Н. ЦЭРЭН

Утас: 95083637

 <p>БАТЛАВ БҮРЭГХАНГАЙ СУМЫН ЗАСАГ ДАРГА М.БАДАМ 2023 оны 06 дугаар сарын 14-ны өдөр</p>	 <p>ГЭРЭЛ БАТЛАВ ГЭРЭЛТ ШИНЭЧЛЭЛ ХХК-ийн ЗАХИРАЛ Н.ЦЭРЭН 2023 оны 06 дугаар сарын 14-ны өдөр</p>	
БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ, УУРХАЙ АШИГЛАХ, ҮЙЛДВЭР БАЙГУУЛАХТАЙ ХОЛБОГДСОН ДЭД БҮТЦИЙГ ХӨГЖҮҮЛЭХ АЖЛЫН БАЙР НЭМЭГДҮҮЛЭХ ТУХАЙ НИЙГМИЙН ХАРИУЦЛАГЫН ГЭРЭЭ		
2023 оны 06-р сарын 14-ны өдөр	№	Бүрэгхангай сум
<p>Энэхүү гэрээг нэг талаас Булган аймгийн Бүрэгхангай сумын Засаг дарга Маналжав овогтой Бадам /цаашид “нутгийн захиргааны байгууллага” гэх/, нөгөө талаас ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч ГЭРЭЛТ ШИНЭЧЛЭЛ ХХК-ийн захирал Норсоо овогтой Цэрэн /цаашид “Тусгай зөвшөөрөл эзэмшигч, бичил уурхайн нөхөрлөл” гэх/ нар /цаашид хамтад нь “Талууд” гэх/ Монгол улсын “Ашигт малтмалын тухай” хуулийн 42,43,44-р зүйл, ЗЗНДНТУ-ын тухай хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Газрын тухай хууль болон бусад хуулиудийн зүйл заалтуудыг үндэслэл болгон дор дурьдсан нөхцөлүүдийг хэлэлцэн харилцан тохиролцож 2023 оны 06 дугаар сарын 14-ны өдөр Булган аймгийн Бүрэгхангай суманд энэхүү нийгмийн хариуцлагын гэрээг байгуулав.</p>		
Нэг. Нийтлэг үндэслэл		
<p>1.1. Талууд энэхүү гэрээгээр орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа уурхайн ашиглалт, үйлдвэрлэлтэй холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, байгаль орчныг хамгаалах, ажлын байр нэмэгдүүлэх, орон нутгийн урт хугацааны тогтвортой хөгжлийг харилцан уялдаатай хөгжүүлэх, хамтын ажиллагааг бэхжүүлэх зорилгоор гэрээний хугацаанд хамтран хэрэгжүүлэх ажлын төрөл, хугацааны талаар харилцан зөвшилцөж хийгдэх ажлын жагсаалтыг баталж хэрэгжүүлнэ.</p>		
<p>1.2. Энэхүү гэрээгээр орон нутагт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, бичил уурхайн нөхөрлөлүүд нь байгаль орчныг хамгаалах чиглэлээр мөрдөгдөж буй хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, нийгмийн хариуцлагыг дээшлүүлэх, ашигт малтмалын ашиглалтын үйл ажиллагааг тогтвортой хэвийн явуулах, сум, орон нутгийн хөгжилд бодитой дэмжлэг үзүүлэх талаар хамтран ажиллахтай холбогдсон харилцааг зохицуулна.</p>		
<p>1.3. Энэхүү гэрээг MV-021324 дугаартай ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй эзэмшигчтэй байгуулна.</p>		
<p>1.4. Орон нутагт хийх бүтээн байгуулалтын ажлын өртөг болон мөнгөн хандив тусламжийн хэмжээ нь Төсвийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.3-т заасан хэмжээгээр тодорхойлогдоно.</p>		
Хоёр.Хамтын ажиллагааны зарчим		

- 2.1. Мэдээллийн ил тод, нээлттэй байдлыг хангаж ажиллах.
- 2.2. Гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар биелүүлэх, хариуцлагатай ажиллах.
- 2.3. Талууд нь хуулиар хүлээсэн үүргийг харилцан хүндэтгэж, хуулийг дээдлэх

Гурав. Талуудын эрх, үүрэг

3.1. Нутгийн захиргааны байгууллагын эрх, үүрэг

3.1.1. Хууль тогтоомжоор олгогдсон бүрэн эрхийн хүрээнд ашигт малтмал эрэх, хайх, ашиглах үйл ажиллагааг тогтвортой, хэвийн явуулах нөхцлөөр тусгай зөвшөөрөл эзэмшигчийг хангах,

3.1.2. Энэхүү гэрээний хүрээнд хэрэгжүүлэх ажлыг дэмжих, хамтарч ажиллах, орон нутгаас хамааралтай бэлтгэл ажлыг хангах, улс орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжиж буй төсөл, хөтөлбөрүүдтэй давхцуулахгүй байх талаар хяналт тавих,

3.1.3. Гэрээний хүрээнд хэрэгжүүлсэн болон хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа төсөл, арга хэмжээний талаар орон нутгийн иргэдэд мэдээлэл өгч, саналыг нь авах. Гэрээний хэрэгжилтийг хагас, бүтэн жилээр дүгнэж, сумын Засаг даргын зөвлөлийн хуралд тайлагнах.

3.1.4. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн зарласан ажлын байр болон бараа, ажил, үйлчилгээ худалдан авахтай холбогдсон мэдээллийг иргэдэд хүргэн ил тод, нээлттэй хэлбэрээр зохион байгуулах,

3.1.5. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавих,

3.1.6. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн гаргасан хүсэлт, шаардлагыг хууль тогтоомжид нийцүүлэн шийдвэрлэж, зохих хариуг өгөх,

3.1.7. Гэрээнд заагаагүй ажил, санхүүжилтийг болон хуульд заагаагүй татвар, төлбөр хураамжийг тусгай зөвшөөрөл эзэмшигчээс шаардахгүй байх,

3.1.8. Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг тусгай зөвшөөрөл эзэмшигчээс шаардах,

3.2. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн эрх, үүрэг

3.2.1. Үйл ажиллагаагаа хэвийн, тасралтгүй явуулахад орон нутгийн иргэд, хуулийн этгээдийн зүгээс хууль бусаар саад учруулсан тохиолдолд уг асуудлыг зохих журмын дагуу сумын Засаг дарга, Засаг даргын Тамгын газарт тавьж шийдвэрлүүлэх.

3.2.2. Байгаль орчныг хамгаалах чиглэлээр:

- Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулж батлуулах
- га талбайд биологийн нөхөн сэргээлт хийсэн байх,
- га талбайд техникийн нөхөн сэргээлт хийсэн байх,
- Усны бохирдол хомсдлоос сэргийлэх, хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлж, ус ашиглалтыг тоолууржуулах

3.2.3. Орон нутгийн хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажилд дэмжлэг үзүүлж, хамтран ажиллах чиглэлээр:

- Уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх,
- /Нутгийн захиргааны байгууллагаас санал болгосон төсөл, арга хэмжээнээс сонгож, энэ хэсэгт оруулах/

3.2.4. Ажлын байр нэмэгдүүлэх чиглэлээр:

- Орон нутгийн иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, тэднийг сургалтад хамруулах талаар орон нутгийн хөдөлмөрийн байгууллагатай хамтарч ажиллан, шаардлагатай ажлын байр болон түүнд тавих шаардлагыг ил тод, нээлттэй хэлбэрээр нийтэд зарлах
- Нийт ажлын байрны 40 доошгүй хувьд тухайн орон нутгийн иргэдийг зохих түвшиний сургатад хамруулсны үндсэн дээр ажиллуулах

3.2.5. Уурхайн хэрэгцээт бараа бүтээгдэхүүнийг Бүрэгхангай сумын аж ахуйн нэгж, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүнээр хангах чиглэлээр:

- Мах, сүүний хэрэгцээг 100% хангана. /.... бод, бог, литр сүү авна./
- Хүнсний ногооны хэрэгцээг хангана. / тн төмс, ... тн хүнсний ногоо/
- Өргөн хэрэглээний хүнсний бараа бүтээгдэхүүнийг сумын худалдааны аж ахуйн нэгжүүдээс худалдан авах

3.2.6. Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын баталсан байгаль орчныг хамгаалах ажлын төлөвлөгөө, хөтөлбөрийг биелүүлж ажиллах,

3.2.7. Гамшгийн үед сайн дурын үндсэн дээр тухайн орон нутагт техник, тоног төхөөрөмж, ажиллах хүчний болон бусад материаллаг туслалцаа үзүүлэх,

3.2.8. Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж, гэрээний хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллах, нутгийн иргэдэд хагас, бүтэн жилээр мэдээлэл өгч ажиллах,

Дөрөв. Гэрээний хэрэгжилт

4.1. Талууд гэрээг тухай жилийн 1 дүгээр улиралд багтаан байгуулж, гэрээний ил тод байдлыг хангах зорилгоор тухайн орон нутгийн иргэдэд гэрээ байгуулсан талаар мэдээлэх бөгөөд гэрээ, түүнтэй холбогдсон баримт бичгийг талуудын цахим хуудсанд ажлын 3 хоногийн дотор байршуулна. Гэрээний хувийг ажлын 5 хоногийн дотор аймаг, сумын Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлагын дэд зөвлөлд хүргүүлнэ.

4.2. Талууд гэрээний хэрэгжилтийг хагас, бүтэн жилээр дүгнэж, аймаг, сумын Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлагын дэд зөвлөлөөр баталгаажуулан, хагас жилийн хэрэгжилтийг 07 дугаар сарын 20-ны өдрийн дотор, жилийн эцсийн хэрэгжилтийг дараа оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор сумын Засаг даргын Тамгын газарт ирүүлнэ.

4.3. Орон нутагтай байгуулсан Нийгмийн хариуцлагын гэрээний хагас, бүтэн жилийн хэрэгжилтийг хавсралтад заасны дагуу сумын Засаг даргын Тамгын газрын Байгаль орчны алба, Санхүүгийн алба 02 дугаар сарын 20-ны өдрийн дотор дүгнэж, сумын Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн сумын Иргэдийн төлөөлөгчдийн Тэргүүлэгчдийн хуралд танилцуулна.

Тав. Гэрээний хариуцлага

5.1. Талууд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд Зөрчлийн тухай хууль болон холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ. Энэхүү гэрээ нь тусгай зөвшөөрөл эзэмшигч хууль тогтоомжоор хүлээсэн бусад үүргээс татгалзах үндэслэл болохгүй.

Зургаа. Бусад

6.1. Гэрээ байгуулагч аж ахуйн нэгжийн хандив, дэмжлэг туслалцаатайгаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээ нь аймаг, сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, эдийн засаг нийгмийн салбаруудын хөгжлийг тодорхойлсон бодлогын баримт бичигт тусгагдаж тухайн шатны Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын шийдвэрээр баталгаажна.

6.2. Санхүүжүүлэх эх үүсвэр дутагдсанаас хандив, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалт бусад холбогдох мэдээллийг гэрээ байгуулах аж ахуйн нэгжүүдэд урьдчилан хүргүүлж танилцуулан, хэрэгжүүлэх эсэхийг аж ахуйн нэгжийн саналаар сонгуулан зөвшилцөн тохиролцсон байна.

Долоо. Маргаан шийдвэрлэх

7.1. Талууд гэрээний хэрэгжилттэй холбогдсон маргаан, зөрчлийг эв зүйгээр шийдвэрлэхийг эрмэлзэх бөгөөд тохиролцоонд хүрч чадаагүй тохиолдолд гомдлоо шүүхэд гаргаж болно.

Найм. Гэрээ хүчин төгөлдөр болох

8.1. Талуудын гарын үсэг зурсан өдрөөс хойш */тухайн жилдээ/* гэрээ хүчин төгөлдөр үйлчилнэ.

8.2. Талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулж болно. Гэрээнд оруулсан нэмэлт, өөрчлөлт нь гэрээний нэгэн адил хүчинтэй байх бөгөөд түүний салшгүй хэсэг болно.

8.3. Гэрээг 2 хувь үйлдэж, хувийг нутгийн захиргааны байгууллага, тусгай зөвшөөрөл эзэмшигчид тус тус хадгална.

---00000000---